

**ЦАХИМ ГАРЫН ҮСГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН
ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ
ҮНЭЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

УЛААНБААТАР ХОТ
2021 он

ЦАХИМ ГАРЫН ҮСГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ АЖЛЫН ТАЙЛАН

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү үнэлгээний ажлын гол зорилго нь Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зүйл, заалтад тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад оршино.

Үнэлгээ хийхээр сонгож авсан хуулийн төсөл нь хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хувилбар байдлаар боловсруулагдсан болно.

Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн /цаашид “хуулийн төсөл” гэх/ үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”¹-д /цаашид “аргачлал” гэх/ заасны дагуу дараахь үе шаттайгаар хийлээ.

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан 6 шалгуур үзүүлэлтээс 5 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Хүлээн зөвшөөрөгдөх байдал
3. Ойлгомжтой байдал
4. Зардал
5. Харилцан уялдаа зэрэг болно.

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зорилго нь үзэл баримтлалд тусгасан хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх /бүрэн илэрхийлж чадсан эсэх/, хуулийн төслийн үндсэн зорилго нь цахим орчинд иргэн, хуулийн этгээд цахим гарын үсэг хэрэглэхтэй холбоотой харилцааг зохицуулах, түүнд тавигдах эрх зүйн болон техникийн шаардлагыг тогтоох замаар иргэн, хуулийн этгээдийг таних, баталгаажуулахад анхаарч, хуулийн төслийн зохицуулалт, арга хэмжээ нь хуулийн төслийн зорилгод хүрэх боломжтой байна уу гэдгийг үнэллээ. Энэхүү үнэлгээг хийхийн тулд хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага, хуулийн төслийн зорилго болон зорилгод хүрэхэд чиглэгдсэн, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц арга хэмжээ, зохицуулалтыг сонгож авав.

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломж байгаа эсэхийг, мөн хэрэгжүүлэх субъект, байгууллага нь хэн байх вэ гэдгийг тогтоох, тэдгээр байгууллагад

¹Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан

тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо байгаа эсэхийг урьдчилан үнэлэх шалгуур үзүүлэлт юм.

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөлд тодорхой этгээдүүдэд үүрэг хүлээлгэсэн, аж ахуйн нэгж, байгууллагад хүндрэл үүсгэх зохицуулалтыг тусгаагүй тул хүлээн зөвшөөрөгдөх байдал гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгон авах шаардлагагүй.

“Ойлгомжтой байдал”, “Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийг шинэчлэн найруулж байгаа тул хуулийн төслийг бүхэлд нь шалгахаар тооцлоо.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төсөл нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтай томъёологдсон эсэхийг шалгах үүднээс хамаарах этгээдүүдээс санал авах, хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг хийхээр сонголоо.

“Зардал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь төрийн байгууллагад холбогдох зардал үүсгэхээр зохицуулсан байх тул уг субъектэд үүсэх зардлыг “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу тооцохоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгов.

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Харилцаа холбооны тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай зэрэг холбогдох бусад хуульд нийцсэн эсэхийг аргачлалд заасан асуултад хариулах байдлаар үнэлгээг хийхээр тооцов.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад хуулийн төслийн зорилго, зорилт, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх үүднээс хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон хуулийн төслийн зорилго, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийнэ.

Монгол Улсын Их Хурлаас Цахим гарын үсгийн тухай хуулийг 2011 онд баталж, цахим болон тоон гарын үсэг хэрэглэх эрх зүйн үндсийг тогтоож, тоон гарын үсгийн нийтийн түлхүүрийн дэд бүтцийг бий болгохтой холбоотой харилцааг зохицуулж байна. Өөрөөр хэлбэл нийтийн түлхүүр ашиглан мэдээллийг шифрлэн хувиргаж, түүнд хамааралтай хувийн түлхүүрээр мэдээллийг задлах, эсрэгээр мэдээллийг хувийн түлхүүрээр шифрлэсэн бол зөвхөн түүнд хамааралтай нийтийн түлхүүрээр задлах зарчмаар ажиллах нийтийн түлхүүрийн дэд бүтцийг “Үндэсний дата төв” УТҮГ-ын дэргэд байгуулж, иргэн, хуулийн этгээдийг цахим хэлбэрээр таньж, баталгаажуулах нөхцөлийг бүрдүүлсэн.

Цахим гарын үсгийн тухай хуульд заасны дагуу иргэн, хуулийн этгээдэд тоон гарын үсгийн гэрчилгээг тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд олгодог бөгөөд 2015

онд “Мон Пасс” ХХК, 2018 онд “Тридиум и-Секюрити” ХХК, “ВиЭсЭм” ХХК, “Нью компасс” ХХК гэсэн 4 байгууллага Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас сонгон шалгаруулалтын үндсэн дээр тусгай зөвшөөрөл авч, нийт 2021 оны 3 сарын байдлаар 30399 тоон гарын үсгийн гэрчилгээг иргэн, хуулийн этгээдэд олгосон байна. Харин “Үндэсний дата төв” УТҮГ-аас 8008 төрийн албан хаагчид тоон гарын үсгийн гэрчилгээг олгосон хэдий ч одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиар тус байгууллагад тоон гарын үсгийн гэрчилгээ олгох эрх олгогдоогүй байна.

Энэ хуулийг баталснаас хойш 9 жилийн хугацаанд иргэн, хуулийн этгээдэд нийт 38407 тоон гарын үсэг олгогдсон байгаа нь практикт тус хуулийн хэрэгжилт хангалтгүй байгааг бодитойгоор харуулж байна. Өөрөөр хэлбэл, эдгээр олгосон тоон гарын үсгийн ихэнх нь аж ахуйн нэгж, байгууллагад олгогдож, иргэн бүрийг тоон гарын үсэгтэй болгох ажил ихээхэн удаашралтай байгаа юм. Иймд Цахим гарын үсгийн тухай хуулийн зохицуулалтыг олон улсын жишигт нийцүүлэн өөрчлөх, практикт үүсээд байгаа хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэх замаар цахим орчинд цахим гарын үсгийг ашиглан үйл ажиллагаа явуулах боломжийг сайжруулж, түүний хэрэглээг нэмэгдүүлж хуулийн хэрэгжилтийг хангах шаардлагатай байгаа тул Хууль тогтоомжийн тухай хуульд заасан журмын дагуу уг хуулийг боловсронгуй болгох нь зүйтэй гэж үзэн дараах зохицуулалттай байхаар үзэл баримтлалд тусгажээ.

1.Хуулийн төслийн зорилтыг өргөтгөж, цахим хэлбэрээр иргэн, хуулийн этгээд хооронд дамжуулах мэдээлэлд цахим гарын үсэг хэрэглэхтэй холбоотой харилцааг зохицуулахаар тусгаж, хуулийн нэр томьёоны тодорхойлолтыг шинэчлэн олон улсын жишигт нийцүүлэн өөрчилж, илүү ойлгомжтой байхаар томьёолно.

2.Хуулийн төсөлд цахим гарын үсэг хэрэглэх үндэслэл, иргэн, хуулийн этгээдийн хэрэглэх цахим гарын үсгийн тоо, хэлбэрт хязгаар тогтоохгүй байх, иргэн тоон гарын үсэг, хуулийн этгээд цахим тамга хэрэглэх болон тоон гарын үсэг байршуулах хэрэгсэл, түүнд тавигдах шаардлагыг тогтоож, иргэний үнэмлэхийг тоон гарын үсгийн хэрэгслээр ашиглаж болохоор, тоон гарын үсгийн бусад хэрэгслийн төрөлд хязгаар тогтоохгүй байхаар зааж, иргэн, хуулийн этгээд хооронд цахим хэлбэрээр дамжуулах мэдээллийг үүсгэсэн, өөрчилсөн, илгээсэн, хүлээн авсан, хадгалсан хугацааг тогтоох зорилгоор тоон гарын үсгийн цагийн бүртгэлтэй байх талаар шинэ зохицуулалтыг оруулна.

3.Хуулийн төсөлд тоон гарын үсэг, цахим тамга нь гэрчилгээжүүлэх байгууллагаас олгосон тоон гарын үсгийн гэрчилгээтэй байхаар, гэрчилгээнд тусгавал зохих мэдээлэл, гэрчилгээний хүчинтэй байх хугацаа, гэрчилгээний үнэ, гэрчилгээний мэдээллийн сан, гэрчилгээ эзэмшигчийн талаарх зохицуулалтыг цогц байдлаар тусгана.

4.Хуулийн төсөлд гэрчилгээ эзэмших хүсэлтийг иргэн улсын бүртгэлийн байгууллагад, хуулийн этгээдийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тусгай зөвшөөрөл эзэмшигчид гаргахаар, ирүүлсэн хүсэлтийг эдгээр байгууллага хүлээн авч иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл үнэн зөв, бичиг баримт нь хүчинтэй эсэхийг шалгасны үндсэн дээр гэрчилгээ олгох, эсхүл хүсэлт гаргагчийн мэдээлэл зөрүүтэй бол хүсэлтийг хүсэлт гаргагчид буцаахаар, гэрчилгээ олгосны дараа хуульд заасан үндэслэлээр гэрчилгээг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохоор тусгана. Мөн гадаад улсын гэрчилгээг Монгол Улсад хүлээн зөвшөөрөх тохиолдлыг гадаад улс орнуудын жишигт нийцүүлэн өөрчилнө.

5.Хуулийн төсөлд гэрчилгээжүүлэх байгууллагад Улсын бүртгэлийн байгууллага, Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу тоон гарын үсгийн гэрчилгээ олгох тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийг хамааруулахаар тусгаж, тэдгээрийн эдлэх эрх, хүлээх үүргийн талаар тодруулна. Мөн гэрчилгээжүүлэх байгууллага нь гэрчилгээ олгохтой холбогдуулан өөрийн үйл ажиллагааны нээлттэй байдлыг хангах, хуульд заасан зарим мэдээллийг нийтэд ил болгох үүрэг хүлээнэ. Түүнчлэн гэрчилгээжүүлэх байгууллага нь гэрчилгээ авах, түүнийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох талаар хүсэлт гаргагчийн гаргасан хүсэлтийг хүлээн авах, холбогдох мэдээллийг шалгасан талаар бүртгэл хөтөлж, бүртгэлийг хадгалахаар, тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дээрх үүргийг гүйцэтгэх бүртгэлийн нэгжтэй байхаар, эсхүл гэрээний үндсэн дээр бусад этгээдээр гүйцэтгүүлэхээр тусгана.

6.Хуулийн төсөлд гэрчилгээ олгох үйл ажиллагааг харилцаа холбоо, мэдээллийн технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх, уг зөвшөөрлийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа компанид олгох зохицуулалтыг хэвээр үлдээж, тусгай зөвшөөрөл хүсэгчид тавигдах шаардлага, тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг, тусгай зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрлийн хугацаа, түүнийг сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, хүчингүйд тооцох, тусгай зөвшөөрөл эзэмшигчид хориглох зүйлийн талаарх зохицуулалтыг өөрчилж тусгана.

7.Хуулийн төсөлд нийтийн түлхүүрийн дэд бүтэц нь Монгол Улсын Үндэсний гэрчилгээжүүлэх байгууллага, гэрчилгээжүүлэх байгууллага, бүртгэлийн нэгжээс бүрдэхээр, нийтийн түлхүүрийн дэд бүтцийн талаар харилцаа холбоо, мэдээллийн технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, Харилцаа холбооны зохицуулах хорооны хэрэгжүүлэх чиг үүргийг тогтооно.

Хуулийн төслийн үзэл баримтлалд туссан дээрх үндэслэл, хэрэгцээ шаардлагаас дүгнэвэл Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үндсэн зорилго нь цахим гарын үсэг, тэр дундаа тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх замаар иргэн бүрт тоон гарын үсэг олгож цахим орчинд иргэн, хуулийн этгээдийг таньж баталгаажуулах, цахим засаглалыг хөгжүүлэх бөгөөд дараах хэд хэдэн дэд зорилт байна гэж үзнэ. Үүнд:

1. Одоогийн үйлчилж байгаа зохицуулалтыг олон улсын жишигт нийцүүлэн тогтоох;
2. Хуульд хэрэглэгдэж байгаа ойлголт, нэр томъёог ойлгомжтой, тодорхой болгох;
3. Холбогдох журмаар зохицуулж байсан цахим гарын үсэг хэрэглэхтэй холбоотой суурь харилцааг хуулиар зохицуулах;
4. Хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах.

Аливаа хуулийн зохицуулалт нь хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн байх ёстой учраас хамгийн эхэнд хуулийн төслийн зорилгыг хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлага, үндэслэл болон зорилготой харьцуулан дараах байдлаар үнэлэх хэсгээ тогтоолоо.

Хуулийн төслийн хэрэгцээ шаардлага /Үндсэн зорилго, дэд зорилго/ хуулийн төслийн үзэл баримтлалаас	Хуулийн төслийн зорилго
---	------------------------------------

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн “Засаглалын бодлого” хэмээх Дөрөвдүгээр бүлгийн 4.1-д “Цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэнэ.” гэж, 4.1.3-т “Цахим засаглалын тогтолцоог боловсронгуй болгож, технологийн дэд бүтэц, төрийн цахим үйлчилгээг нэгдсэн бодлого, төлөвлөлттэй хөгжүүлнэ.” гэж тус тус заасан. Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.3.1-д “Мэдээллийн аюулгүй байдлын, цахим гарын үсгийн, мэдээллийн сангийн, хувь хүний мэдээллийн аюулгүй байдлын зэрэг цахим засаглалыг хөгжүүлэхэд шаардагдах хууль тогтоомжийг боловсруулж батлуулан, түүнтэй нийцүүлэн холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулна.” гэж, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 75 дугаарт Монгол Улсын Засгийн газар Цахим гарын үсгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг санаачлан боловсруулахаар тусгасан.	1 дүгээр зүйл.Хуулийн зорилт 1.1.Энэ хуулийн зорилт нь цахим орчинд иргэн, хуулийн этгээд цахим гарын үсэг хэрэглэхтэй холбоотой харилцааг зохицуулах, түүнд тавигдах эрх зүйн болон техникийн шаардлагыг тогтоох замаар иргэн, хуулийн этгээдийг таних, баталгаажуулахад оршино.
--	--

Түүнчлэн хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийн зорилгыг хангахад чиглэсэн эсэхийг үнэлэх үүднээс хуулийн төслийн зорилго, зорилтод хүрэхэд чиглэсэн дараахь зохицуулалтын үр нөлөөг үнэлэхээр сонголоо.

Хуулийн төслийн 3.1, 4.1, 5.1 дэх хэсэг, 6, 7, 8, 11, 12 дугаар зүйлийг сонгон авлаа.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн Дөрөвдүгээр бүлэгт болон Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг, түүнчлэн хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүд хуулийг ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байдлаар боловсруулагдсан эсэхийг шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь сонгон авлаа. /Хуулийн төсөл 9 бүлэг, 35 зүйлтэй./

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь авч үзэхээр тооцлоо. /Хуулийн төсөл 9 бүлэг, 35 зүйлтэй./

**ДӨРӨВ.УРЬДЧИЛАН СОНГОСОН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ
ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ
ҮНЭЛСЭН БАЙДАЛ**

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар харуулъя.

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн 3.1, 4.1, 5.1 дэх хэсэг, 6, 7, 8, 11, 12 дугаар зүйл	Зорилгод дүн шинжилгээ хийх
2	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	<u>Ойлгомжтой байдлыг судлах</u>
3	Зардал	Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын дагуу тусад нь тооцно.	Зардлын тооцоо хийх
4	Харилцан уялдаа	Хуулийн төсөл бүхэлдээ	Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараахь байдлаар үнэллээ.

“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Энэ хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлагыг хуулийн төсөлд томъёолсон зорилго, зорилт болон зохицуулалттай харьцуулан үзлээ. Хуулийн төслийн үзэл баримтлалаас харахад “цахим гарын үсэг, тэр дундаа тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх замаар иргэн бүрт тоон гарын үсэг олгож цахим орчинд иргэн, хуулийн этгээдийг таньж баталгаажуулах, цахим засаглалыг хөгжүүлэх” үндсэн зорилго дэвшүүлсэн байна.

Харьцуулсан дүн шинжилгээг хийж үзэхэд хуулийн зорилгыг хуулийн төслийн 1 дүгээр зүйлд “Энэ хуулийн зорилт нь цахим орчинд иргэн, хуулийн этгээд цахим гарын үсэг хэрэглэхтэй холбоотой харилцааг зохицуулах, түүнд тавигдах эрх зүйн болон техникийн шаардлагыг тогтоох замаар иргэн, хуулийн этгээдийг таних, баталгаажуулахад оршино.” гэж томъёолсноор уг хууль нь цахим гарын үсэг хэрэглэх, түүнд тавигдах нөхцөл, шаардлагыг тогтоож, иргэн, хуулийн этгээд энэхүү нөхцөл, шаардлагад нийцүүлэн цахим гарын үсгийг хэрэглэн цахим орчинд өөрийгөө таниулах замаар тодорхой үйл ажиллагаа явуулах боломжийг бүрдүүлж болохоор байгаа нь хуулийн төслийн зорилгоо бүрэн тодорхойлж чадсан гэж үзэхээр байна.

Хуулийн төслийн зохицуулалтууд нь хуулийн төслийн зорилгыг хангахад чиглэсэн эсэх, тэдгээр нь зорилгыг хангах боломжтой байдлаар томъёологдсон эсэхийг үнэлэхээр хуулийн төслийн зорилгыг сонгож авсан дараахь зохицуулалтуудтай харьцуулан дүн шинжилгээ хийлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт дүн шинжилгээ хийсэн байдал:

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Төрийн нууцад хамааруулснаас бусад мэдээллийг цахим орчинд иргэн, хуулийн этгээд хооронд дамжуулахтай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Цахим гарын үсгийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад мэдээ, баримт бичгийг цахим хэлбэрээр шилжүүлэх, дамжуулахтай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна.” гэж тусгасан хуулийн үйлчлэх хүрээг өөрчилж зөвхөн төрийн нууцтай холбоотой мэдээлэл дамжуулахад цахим гарын үсэг хэрэглэхгүй байхаар зааж, албаны болон байгууллагын нууцтай холбоотой мэдээлэл дамжуулахад цахим гарын үсэг хэрэглэхэд хязгаар тогтоогоогүй байгаа нь хуулийн төслийн зорилт болон үзэл баримтлалаар дэвшүүлсэн хуулийн үйлчлэх хүрээг өргөжүүлэх замаар цахим гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэсэн зохицуулалт болжээ.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт дүн шинжилгээ хийсэн байдал:

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“цахим гарын үсэг” гэж цахим хэлбэрээр дамжуулах мэдээлэлд гарын үсэг зурсан этгээдийг тодорхойлох зорилгоор мэдээлэлд хавсаргасан, эсхүл нэгтгэсэн цахим өгөгдлийг;

4.1.2.“тоон гарын үсэг” гэж энэ хуулийн 6.2-т заасан шаардлагыг хангаж, гэрчилгээжүүлэх байгууллагаас иргэн, хуулийн этгээдэд олгосон гэрчилгээгээр баталгаажсан цахим гарын үсгийг;

4.1.3.“тоон гарын үсгийн гэрчилгээ” гэж иргэн, хуулийн этгээдийг таних зорилгоор гэрчилгээжүүлэх байгууллагаас тоон гарын үсэг эзэмших эрхийг олгосон, нийтийн түлхүүр, холбогдох бусад мэдээллийг агуулсан цахим баримт бичгийг;

4.1.4.“гэрчилгээ эзэмшигч” гэж тоон гарын үсгийн гэрчилгээнд заасан тоон гарын үсэг, цахим тамга хэрэглэх хувийн түлхүүр эзэмшигч иргэн, хуулийн этгээдийг;

4.1.5.“криптограф” гэж мэдээллийг нуух аргачлалыг судалдаг математикийн салбар шинжлэх ухааныг;

4.1.6.“цахим баримт бичиг” гэж Нийтийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасныг;

4.1.7.“тоон гарын үсгийн хувийн түлхүүр /цаашид “хувийн түлхүүр” гэж/” гэж тоон гарын үсгийг үүсгэх, өгөгдлийг тайлах зориулалттай тэмдэгтийн давтагдашгүй дарааллыг;

4.1.8.“тоон гарын үсгийн нийтийн түлхүүр /цаашид “нийтийн түлхүүр” гэх/” гэж хувийн түлхүүртэй математик хамааралтай, өгөгдлийг нууцлах, тоон гарын үсгийг шалгах зориулалттай тэмдэгтийн дарааллыг;

4.1.9.“тоон гарын үсгийн хэрэгсэл” гэж хувийн түлхүүр ашиглан тоон гарын үсгийг үүсгэх, нийтийн түлхүүр ашиглан тоон гарын үсгийг шалгах, тоон гарын үсгийн нийтийн болон хувийн түлхүүрийг үүсгэх боломжтой техник хэрэгсэл, программ хангамжийг;

4.1.10.“гэрчилгээжүүлэх байгууллага” гэж тоон гарын үсэг эзэмших эрхийн гэрчилгээ олгох Улсын бүртгэлийн байгууллага, тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийг;

4.1.11.“гэрчилгээжүүлэх ажиллагааны журам” гэж гэрчилгээжүүлэх байгууллагын үйл ажиллагаанд тавигдах шаардлага, аюулгүй байдлын хяналтыг тодорхойлсон баримт бичгийг.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4 дэх хэсэгт зааснаар нэр томьёо нь олон утгатай, нэр томьёо нь өргөн утгатай бөгөөд түүнийг нарийвчлан тодорхойлох шаардлагатай, шинээр бий болсон ойлголт буюу нэр томьёо нь нийтэд ойлгомжгүй бол хуулийн төсөлд нэр томьёоны тайлбар хийхээр заасан.

Хуулийн төсөлд хэрэглэсэн “цахим гарын үсэг”, “тоон гарын үсэг”, “тоон гарын үсгийн гэрчилгээ, түүнийг эзэмшигч”, “цахим баримт бичиг”, “тоон гарын үсгийн хэрэгсэл”, “тоон гарын үсгийн нийтийн болон хувийн түлхүүр” зэрэг ойлголтууд нь агуулгын хувьд өргөн утгатай, практикт хэрхэн ойлгох нь тодорхойгүй, хууль хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэх, хууль эрх зүйн маргаан дагуулж болзошгүйг харгалзан нэр томьёоны тайлбар хийжээ.

Тухайлбал; “цахим гарын үсэг”-ийг илүү өргөн утга агуулгаар тогтоож, түүний нэг хэсэг нь “тоон гарын үсэг” байхаар, иргэн тоон гарын үсэг, хуулийн этгээд иргэний хэрэглэх тоон гарын үсгээс нэршлийн хувьд ялгаатай хэдий ч тавигдах шаардлага, аюулгүй байдлын хангах нөхцөлийн хувьд ижил тоон гарын үсгийг цахим тамга хэлбэрээр хэрэглэхээр, “цахим баримт бичиг”-ийг Нийтийн мэдээллийн тухай хуулиас эш татаж тодорхойлон хууль хоорондын уялдаа холбоог хангасан байна. Түүнчлэн “тоон гарын үсгийн нийтийн болон хувийн түлхүүр”-ийг ашиглан тоон гарын үсэг үүсгэх, түүнийг шалгах замаар тоон гарын үсэг хэрэглэхэд тавигдах шаардлагыг тогтоосон, тоон гарын үсэг эзэмших эрхийн гэрчилгээ олгох байгууллагаар Улсын бүртгэлийн байгууллага, тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд байхаар Эстони, Бүгд Найрамдах Турк Улсын жишгийг харгалзан томьёоллыг өөрчлөн тогтоосон зэрэг нь цахим гарын үсгийг хэрэглэхтэй холбоотой харилцааг цогц байдлаар зохицуулж, иргэн, хуулийн этгээд хуулийг дагаж мөрдөхөд ямарваа нэгэн маргаан, ойлгомжгүй, зөрүүтэй байдал үүсгэхээс сэргийлж хуулийн хэрэгжилтийг хангах тухай үзэл баримтлалаар дэвшүүлсэн зорилгод нийцэж байна.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт дүн шинжилгээ хийсэн байдал:

5 дугаар зүйл.Цахим гарын үсэг хэрэглэх

5.1.Хуульд өөрөөр заагаагүй бол мэдээллийн системийн тусламжтайгаар цаасан хэлбэрт байгаа мэдээллийг цахим хэлбэрт шилжүүлсэн, эсхүл цахим орчинд үүсгэсэн, илгээсэн, хүлээн авсан, хадгалагдсан, хандах боломжтой мэдээллийг цахим хэлбэрээр дамжуулахад цахим гарын үсэг хэрэглэнэ.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Цахим гарын үсгийн тухай хуулиар цахим гарын үсэг хэрэглэх тохиолдлыг тодорхой заагаагүй, зөвхөн цахим баримт бичигт хэрэглэж болох агуулгаар тусгагдсаныг өөрчлөн цаасан хэлбэрт байгаа мэдээллийг цахим хэлбэрт шилжүүлсэн, эсхүл цахим орчинд үүсгэсэн, илгээсэн, хүлээн авсан, хадгалагдсан, хандах боломжтой мэдээллийг цахим хэлбэрээр дамжуулахад цахим гарын үсэг хэрэглэхээр зааж хуулийн үйлчлэх хүрээг өргөжүүлэн тогтоосон нь хуулийн хэрэглээг нэмэгдүүлэх талаар үзэл баримтлалаар тогтоосон зорилгод хүрсэн байна.

Гадаад улс орны туршлагаас харахад хуулийн үйлчлэх хүрээг өргөн хүрээнд тавьдгаас цахим гарын үсгийн хэрэглээг тэр утгаар нэмэгдүүлдэг байна. Израиль улсын Цахим гарын үсгийн тухай хууль 2001 онд батлагдсан бөгөөд гол зорилго нь тодорхой цахим хэрэгслийг ашиглан хувь хүнийг баталгаажуулах, гарын үсэг зурсан нотолгоог таних замаар цахим хэлбэрээр, ялангуяа интернетээр дамжуулан гүйцэтгэх үйл ажиллагааны тодорхой байдлыг нэмэгдүүлэхэд чиглэснээр үйлчлэх хүрээг зөвхөн цахим баримт бичгээр хязгаарлалгүйгээр үйл ажиллагаа гэсэн агуулгаар зохицуулалтыг хийсэн байна.

Хуулийн төслийн 6 дугаар зүйлд дүн шинжилгээ хийсэн байдал:

6 дугаар зүйл. Тоон гарын үсэг хэрэглэх

6.1. Тоон гарын үсгийн гэрчилгээнд заасан хувийн түлхүүр эзэмшигч иргэн тоон гарын үсэг хэрэглэнэ.

6.2. Тоон гарын үсэг нь дараах шаардлагыг хангасан байна:

6.2.1. хувийн түлхүүр ашиглан мэдээллийг криптограф хувиргалтад оруулж үүсгэсэн;

6.2.2. тоон гарын үсгийн гэрчилгээ эзэмшигчийг нийтийн түлхүүр ашиглан таних, шалгах боломжтой;

6.2.3. мэдээлэлд тоон гарын үсгийг хавсаргасан, эсхүл нэгтгэсний дараа мэдээлэл болон тоон гарын үсэгт өөрчлөлт оруулсан, мэдээллийн бүрэн бүтэн эсэхийг мэдэх боломжтой.

6.3. Тоон гарын үсэг нь цаасан хэлбэрт байгаа мэдээлэлд зурсан гарын үсэгтэй адил хүчинтэй байна.

6.4. Төрийн албан хаагч энэ хуулийн 6.1-д зааснаас гадна төрийн албан тушаалыг эрхэлж, эрх, үүргээ хэрэгжүүлэхдээ тоон гарын үсэг хэрэглэж болно.

6.5. Хуулийн этгээд тоон гарын үсэг хэрэглэж болох бөгөөд хуулийн этгээдийн хэрэглэх тоон гарын үсэг нь цахим тамга байна.

Энэ хуулийн 6 дугаар зүйлээр тоон гарын үсэгт тавигдах шаардлага, тоон гарын үсэг нь цаасан хэлбэрт байгаа мэдээлэлд зурсан гарын үсэгтэй адил хүчинтэй байх, хуулийн этгээд цахим тамга хэрэглэх зэрэг ойлголтыг Европын холбоо 1999 онд “Цахим гарын үсгийн удирдамж”-ийг баталж, 2014 онд зохицуулалтыг шинэчлэн, 2016 оноос холбооны бүх улсуудад хэрэгжиж эхэлсэн “Цахимаар таних болон Итгэмжлэгдсэн үйлчилгээний журам” (eDIAS No 910/2014)-ын зохицуулалт болон бусад улс орнуудын

Цахим гарын үсгийн талаарх хуулиудад нийцүүлэн тогтоосон нь үзэл баримтлалаар тогтоосон хуулийн зохицуулалтыг олон улсын жишигт хүргэх шаардлагад нийцнэ гэж үзэж байна.

Түүнчлэн Бүгд Найрамдах Хятад Ард Улсад тоон гарын үсгийг өргөнөөр хэрэглэж, хэд хэдэн шүүхийн маргаан үүсэж, шүүхээс гаргасан шийдвэр нь тоон гарын үсгийг бичмэл гарын үсэгтэй ижил хүчинтэйд тооцдог болохыг харуулсан байдаг. Тоон гарын үсэг, тоон баримт зэрэг баримт бичгийг талууд хэрэглэхээр тохирсон бол зөвхөн тоон гарын үсэг, тоон баримтын хэлбэрийг ашигласан гэсэн шалтгаанаар түүний эрх зүйн үр дагаврыг үгүйсгэхгүй байхаар зохицуулжээ. Мөн Бүгд Найрамдах Солонгос Улсын жишээг харахад тоон гарын үсгийг Худалдааны ерөнхий гэрээ, Хөдөлмөрийн гэрээ, Түрээсийн гэрээ болон бусад нийтлэг төрлийн гэрээг байгуулахад түгээмэл ашигладаг байна. Өмнөд Солонгосын хууль тогтоомжийн дагуу тоон гарын үсэг нь хууль ёсны шаардлагыг хангасан тохиолдолд энгийн гарын үсэгтэй ижил түвшинд хэрэглэгдэж, хүлээн зөвшөөрөгдөх боломжтой байдаг.

Хуулийн төслийн 7 дугаар зүйлд дүн шинжилгээ хийсэн байдал:

7 дугаар зүйл.Цахим тамга хэрэглэх

7.1.Тоон гарын үсгийн гэрчилгээнд заасан хувийн түлхүүр эзэмшигч хуулийн этгээд цахим тамгыг хэрэглэнэ.

7.2.Хуулийн этгээд цахим тамгыг хууль, эсхүл гэрээнд өөрөөр заагаагүй бол тамга дарсан буюу дарах ёстой баримт бичгийг цахим хэлбэрээр дамжуулахад хэрэглэнэ.

7.3.Цахим тамгыг хуулийн этгээдийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд эзэмшинэ.

7.4.Цахим тамга нь энэ хуулийн 6.2-т заасан шаардлагыг хангасан байна.

7.5.Хуулийн этгээд цахим тамгагүй бол хуулийн этгээдийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдийн энэ хуулийн 6.1-д заасны дагуу эрх бүхий байгууллагаас олгосон тоон гарын үсгийг хэрэглэнэ.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Цахим гарын үсгийн тухай хуульд цахим тамга хэрэглэх зохицуулалт байхгүй бөгөөд иргэний хэрэглэж байгаа тоон гарын үсгээс нэр томьёоны хувьд ялгах, нөгөө талаас тамга дарсан буюу дарах ёстой баримт бичгийг цахим хэлбэрээр дамжуулахад цахим тамгыг хэрэглэхээр тусгасан байна. Гэхдээ хуулийн этгээдэд сонголтыг өгч хуулийн этгээд нь цахим тамгагүй бол хуулийн этгээдийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдийн тоон гарын үсгийг хэрэглэж болохоор заасан байна.

Түүнчлэн цахим тамга хэрэглэх талаар өмнө дурдсан Европын холбооны 1999 онд “Цахим гарын үсгийн удирдамж”-ийг баталж, 2014 онд зохицуулалтыг шинэчлэн, 2016 оноос холбооны бүх улсуудад хэрэгжиж эхэлсэн “Цахимаар таних болон Итгэмжлэгдсэн үйлчилгээний журам” (eDIAS No 910/2014)-ын зохицуулалт болон бусад улс орнуудын Цахим гарын үсгийн талаарх хуулиудад зохицуулсан байх бөгөөд ийнхүү олон улсын жишигт нийцүүлэн тогтоосон нь үзэл баримтлалаар тогтоосон шаардлагад нийцнэ гэж үзэж байна.

Хуулийн төслийн 8 дугаар зүйлд дүн шинжилгээ хийсэн байдал:

8 дугаар зүйл.Тоон гарын үсгийн хэрэгсэл, түүнд тавигдах шаардлага

8.1.Тоон гарын үсэг үүсгэх болон хувийн түлхүүрийг хадгалж, хэрэглэхэд дараах шаардлагыг хангасан тоон гарын үсгийн хэрэгсэл ашиглана:

8.1.1.хувийн түлхүүрийг хууль бусаар ашиглахаас урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлсэн байх;

8.1.2.хувийн түлхүүр болон нийтийн түлхүүрийг үүсгэх, дамжуулахдаа түүний давтагдашгүй байдал болон нууцлалыг хангасан байх.

8.2.Тоон гарын үсгийн хэрэгсэлд тоон гарын үсгийн гэрчилгээ, хувийн түлхүүрийг байршуулна.

8.3.Иргэний үнэмлэхийг тоон гарын үсгийн хэрэгслээр ашиглаж болох бөгөөд энэ хуулийн 8.2-т заасан мэдээллийг түүний санах ойд байршуулна.

8.4.Иргэн иргэний үнэмлэхээс бусад төрлийн тоон гарын үсгийн хэрэгсэл ашиглахаар бол тусгай зөвшөөрөл эзэмшигчид хүсэлт гаргаж, энэ хуульд заасан журмын дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч тоон гарын үсгийг олгож, холбогдох мэдээллийг Улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлнэ.

8.5.Тоон гарын үсгийн хэрэгслийн төрөлд хязгаар тогтоохгүй бөгөөд шаардлага хангасан тоон гарын үсгийн хэрэгслийн төрлийн жагсаалтыг харилцаа холбоо, мэдээллийн технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага гаргаж, нийтэд мэдээлнэ.

Тоон гарын үсэг болон тоон гарын үсгийн хэрэгсэлд тавигдах шаардлага хоорондын ялгааг тодруулж, тоон гарын үсгийн хэрэгсэлд байршуулах мэдээлэлд юуг хамааруулахыг тогтоож, иргэний үнэмлэхийг тоон гарын үсгийн хэрэгслээр ашиглаж болохоор, улмаар тоон гарын үсгийн хэрэгслийн төрөлд хязгаар тогтоохгүй байхаар зохицуулжээ. Иргэний үнэмлэхийн санах ойд тоон гарын үсгийн гэрчилгээ, хувийн түлхүүрийг байршуулж, тоон гарын үсгийн гэрчилгээ олгоход улсын бүртгэлийн байгууллагын мэдээллийн санд хадгалагдаж байгаа иргэний мэдээлэлд үндэслэн, түүнийг таньж баталгаажуулахад хүндрэл үүсгэхгүйгээр олгох ажиллагааг хуульчилж байгаа нь Эстони Улсад тоон гарын үсгийг тохиромжтой гэж үзсэн хэрэгсэл буюу иргэний үнэмлэхийн санах ой, гар утасны сим картанд тоон гарын үсгийг байршуулан ашиглаж байгаа жишигт үндэслэсэн төдийгүй тоон гарын үсгийн гэрчилгээг олгохдоо хүсэлт гаргагчийн үнэн зөв, бодит мэдээлэлд үндэслэдэг зарчмыг хэрэгжүүлэхэд үр дүнтэй зохицуулалт болохоор байна.

Хуулийн төслийн 11, 12 дугаар зүйлд дүн шинжилгээ хийсэн байдал:

11 дүгээр зүйл.Гэрчилгээний хүчинтэй байх хугацаа

11.1.Гэрчилгээг иргэнд 5 жил, хуулийн этгээдэд 3 жил, гадаадын иргэнд түүний оршин суух хугацаагаар, эсхүл 5 жилээс дээш хугацаагаар оршин суух бол гэрчилгээг 5 жилийн хугацаагаар олгоно.

11.2.Гэрчилгээний хүчинтэй байх хугацааг гэрчилгээнд заасан гэрчилгээжүүлэх байгууллагын олгосон өдрөөс дуусах өдөр хүртэлх хугацаагаар тооцно.

12 дугаар зүйл.Гэрчилгээний үнэ

12.1.Гэрчилгээний үнэ нь дараах үнээс бүрдэнэ:

12.1.1.иргэн, хуулийн этгээдэд олгох тоон гарын үсэг, цахим тамгын үнэ;

12.1.2.тоон гарын үсгийн хэрэгслийн үнэ.

12.2.Улсын бүртгэлийн байгууллагаас иргэнд олгох тоон гарын үсгийг иргэний үнэмлэхийн санах ойд байршуулахад энэ хуулийн 12.1 дэх хэсэг үйлчлэхгүй.

12.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс хуулийн этгээдэд олгох гэрчилгээний үнийг Харилцаа холбооны зохицуулах хорооноос тогтоосон гэрчилгээ олгох үйлчилгээний тариф тогтоох аргачлалын дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрөө тогтооно. хэрэв 5 жилээс дээш хугацаагаар оршин суух бол гэрчилгээг 5 жилийн хугацаагаар олгоно.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиар тоон гарын үсгийн гэрчилгээг 2 хүртэл жилийн хугацаагаар олгохоор заасныг уртасгаж, иргэнд 5 жил, хуулийн этгээдэд 3 жил, гадаадын иргэнд түүний оршин суух хугацаагаар, эсхүл 5 жилээс дээш хугацаагаар оршин суух бол гэрчилгээг 5 жилийн хугацаагаар олгохоор ялгамжтайгаар тогтоосон нь Эстони Улс 2019 оноос хойш гэрчилгээг 5 жилийн хугацаагаар олгож байгаа жишигт нийцүүлсэн байна. Мөн хуулийн этгээдийн төлөөлөх эрх бүхий этгээд богино хугацаанд солигдох магадлал байдгийг харгалзан 3 жилийн хугацаагаар, мөн энэ хуулийн нэг онцлог зохицуулалт нь гадаадын иргэн гэрчилгээжүүлэх байгууллагаас тоон гарын үсгийн гэрчилгээ авч болох үндсийг тогтоож, хугацааг түүний оршин суух хугацаанаас хамааран ялгаатай байхаар уян хатан зохицуулсан байна. Ингэснээр иргэн, хуулийн этгээд 2 хүртэл жилээр олгосон тоон гарын үсгээ дахин дахин солих, тэр бүртгээ гэрчилгээний үнэ төлдөг байсан жишгийг өөрчилсөн байна. Мөн Улсын бүртгэлийн байгууллагаас иргэнд олгох тоон гарын үсгийг иргэний үнэмлэхийн санах ойд байршуулахад иргэнээс гэрчилгээний үнэ авахгүй байхаар зохицуулсан нь тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэхэд ихээхэн ач холбогдолтой гэж дүгнэхээр байна.

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломж байгаа эсэхийг, мөн хэрэгжүүлэх субъект, байгууллага нь хэн байх вэ гэдгийг тогтоох, тэдгээр байгууллагад тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо байгаа эсэхийг урьдчилан үнэллээ.

Хуулийн төслийг практик дээр турших нь тухайн зохицуулалт практикт хэрэгжих боломжтой байна уу, хуулийг хэрэгжүүлэх байгууллагууд түүнийг хүлээн зөвшөөрч байна уу, бусад этгээдэд хэрхэн нөлөөлж байгаа болон тухайн зохицуулалтад байгаа хийдэл, дутагдалтай зүйлийг тогтооход чухал ач холбогдолтой хэдий ч энэ нь маш их цаг хугацаа, хүн хүч, зардал шаардах тул санал авах, асуулга явуулах, одоо болж байгаа үйл явцад дүн шинжилгээ хийх замаар явуулсан.

Уг шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн практикт хэрэгжих боломжийг судлах бөгөөд уг хэсэгт Гэрчилгээжүүлэх байгууллага нь Улсын бүртгэлийн байгууллага, Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу тоон гарын үсгийн гэрчилгээ олгох тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд байхаар тогтоосон байна. Хууль санаачлагчаас 2021 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 1/1258 тоот албан бичгээр хуулийн төсөлд Улсын бүртгэлийн ерөнхий газраас санал авахаар явуулсны дагуу болон Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/223 тоот тушаалаар байгуулагдсан Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах Ажлын хэсэгт тус байгууллагын төлөөлөл орж ажиллан тус байгууллага тоон гарын үсгийн гэрчилгээ олгох байгууллагаар ажиллах боломжтой, мөн иргэний үнэмлэхийг тоон гарын үсгийн хэрэгслээр ашиглах, тоон гарын үсгийн гэрчилгээ, хувийн түлхүүрийг түүний санах ойд байршуулахад яман нэгэн хүндрэл үүсэхгүй талаар хариу ирүүлж тухай бүр дэмжиж байгаа талаар саналаа илэрхийлж оролцсон байна.

Түүнчлэн хуулийн өөрчлөлттэй холбогдуулан Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас сонгон шалгаруулалтын үндсэн дээр тусгай зөвшөөрөл авсан “Мон Пасс” ХХК, “Тридиум и-Секюрити” ХХК, “ВиЭсЭм” ХХК, “Нью компас” ХХК гэсэн 4 байгууллагын саналыг авч “Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд тусгасан болно.

“Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хуулийн төсөл нь хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдүүдэд ойлгомжтой байдлаар томъёологдсон эсэхийг шалгах үүднээс хуулийн төсөлд санал авахаар Засгийн газрын бүх гишүүд /16 сайд/, төрийн бусад болон төрийн бус байгууллагад санал авах тухай албан бичгийг хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, хуулийн төслийн хамтаар хавсарган хүргүүлж, саналыг авав.

Дээрх байгууллагуудаас ирүүлсэн саналуудаас хуулийн төслийн ойлгомжтой байдал гэсэн шалгах хэрэгслийн хүрээнд өгсөн саналыг нэгтгэн судлаад санал өгсөн байгууллагуудын тухайд ойлгомжгүй байгаа зохицуулалтуудыг дараах байдлаар тогтоолоо.

№	Хаанаас	Саналын утга	Тайлбар
1.	Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар 2021.04.08-хэг/952	Таны 2021 оны 1/1258 тоот албан бичгээр ирүүлсэн Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг зарчмын хувьд дэмжиж, дараах саналыг хүргүүлж байна. Нэг.Хуулийн төслийн агуулга, бүтцийн талаар: 1.Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.4, 8.5 дахь хэсгийг хэвээр үлдээх; 2.Хуулийн төслийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийн “... хэрэв 5 жилээс дээш хугацаагаар оршин суух бол гэрчилгээг 5 жилийн хугацаагаар олгоно.” гэсэн 2 дахь өгүүлбэр нь төслийн 11.1 дэх хэсэгтэй агуулгын хувьд давхцаж байгааг анхаарах;	1.Саналыг тусгасан. 2.Саналыг анхаарч томъёоллыг өөрчилсөн.

		3.Хуулийн төслийн 4 дүгээр бүлэгт “Гэрчилгээ олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох”-той холбоотой асуудлыг зохицуулахаар тусгаж, бусад зохицуулалтыг хасах. Хоёр.Хуулийн төслийн томъёолол, хэл, найруулга зүйн талаар: 1.Хуулийн төслийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийн “хүсэлт гаргагч нь” гэсний дараа “Монгол Улсын” гэж нэмэх; 2.Хуулийн төслийн 18 дугаар зүйлийн 18.1.4 дэх заалтын “татан буугдсан” гэсний дараа “өөрчлөн байгуулагдсан,” гэж нэмэх; 3.Хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.2.5 дахь заалтын “сэргээсэн” гэсний дараа хүчингүй болгосон” гэж нэмж, мөн зүйлийн 13.2.6 дахь заалтыг бүхэлд нь хасах; 4.Хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 10.3.1 дэх заалтын “гэрчилгээжүүлэх” гэснийг хасах; 5.Хуулийн төслийн 20 дугаар зүйлийн дугаарлалт алдаатай, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, 21.2.3 дахь заалтад иш татсан заалт нь байхгүй байгаа зэргийг анхаарч эргэн нягтлах нь зүйтэй байна.	3.Зохицуулалтыг хэвээр үлдээсэн. 1.Саналыг тусгасан. 2.Зохицуулалтыг хэвээр үлдээсэн. 3.Саналыг тусгасан. 4.Саналыг тусгасан. 5.Саналыг тусгасан.
2.	Сангийн сайд 2021.04.01-6/1541	Таны 2021 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 1/1258 тоот албан бичгээр ируулсан Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй танилцаад дараах үндэслэлээр дэмжих боломжгүй байна. Үүнд: 1.Хуулийн төслийн 7 дугаар зүйлд цахим тамгыг тамга дарах ёстой баримт бичигт хэрэглэх, түүнийг хуулийн этгээдийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд эзэмшихээр заасан байна. Иргэний хуульд зааснаар хуулийн этгээдийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээдээс гадна итгэмжлэл олгосон этгээд төлөөлөх бүрэн эрхтэй. Гэтэл төсөлд зөвхөн гуйцэтгэх захирал байхаар заасан нь хязгаарлалтыг бий болгосон байна. Нөгөөтээгуур, хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий этгээд тухайн баримт бичгийг цахим гарын үсгээр нэгэнт баталгаажуулсан байхад тамга дарах ёстой баримт бичиг гэсэн үндэслэлээр дахин баталгаажуулах нь хүндрэл бий болгохоор байна. Мөн тамга дарах ёстой баримт бичгийн жагсаалт гэж байдаггүй тул тухайн цахим баримтыг хулээн авагч байгууллагын хувьд хуулийн төслийн 7.2 дахь хэсэгт зааснаар цахим тамга дарах ёстой байсан эсэхийг шалгахад ойлгомжгүй нөхцөл үүсэхээр байна; 2.Цахим гарын үсгийн багагүй хувийг худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулагдаж байгаа тендер	1.Саналыг тусгасан. 2.Саналыг тусгасан.

	шалгаруулалтад оролцоход ашигладаг ба иргэдийн тоон гарын үсгийг олгоход тулгамдаж буй нэг асуудал нь тоон гарын үсэгт тухайн иргэний нэрээс гадна тууний төлөөлөх “хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаар”-ыг тэмдэглэсэн байдаг явдал юм. Хувь хуний тоон гарын үсгийн мэдээлэлд тодорхой хуулийн этгээдийн нэрийг нэрлэн заах нь тухайн хун хуулийн этгээдийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхгүй болсон тохиолдол бургд энэ тухай тоон гарын үсэг олгосон байгууллагад мэдэгдэж, өөрчлөлт оруулдаггүй сөрөг талтай. Энэ нь тухайн тоон гарын үсгийг ашиглаж цаашид ч уг хуулийн этгээдийг төлөөлөх эрхтэй мэт ойлгомжгүй байдлыг үүсгэдэг. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр мөрдөгдсөнөөс хойш Монгол Улс дахь бүх хуулийн этгээдийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийн нэрийг хүндрэлгүйгээр шалгах боломжтой болсон тул тодорхой иргэн аль нэг хуулийн этгээдийн баримт бичигт цахим гарын үсгээ ашигласан нь хүчин төгөлдөр эсэхийг хялбархан шалгах боломжтой болсон. Иймд тоон гарын үсгийн бусдад харагдах мэдээлэл юу байх талаар хуулийн төсөлд тодорхой дурдаж, түүний дотор аль нэг хуулийн этгээдийн нэрийг бичдэг явдлыг халах. Цаашлаад одоо мөрдөгдөж байгаа хуулийн хүрээнд олгогдсон иргэдийн тоон гарын үсгээс хуулийн этгээдийн нэрийн мэдээллийг хасах талаар шилжилтийн үеийн зохицуулалтыг бий болгох шаардлагатай; 3.Хуулийн төслийн 11 дүгээр зүйлд цахим гарын үсгийн гэрчилгээг гадаадын иргэнд олгох бол зөвхөн оршин суух зөвшөөрөлтэй байхыг шаардахаар байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу тодорхой босго үнээс давсан төсөвт өртөгтэй тендер шалгаруулалтад гадаадын иргэн, хуулийн этгээд чөлөөтэй өрсөлдөх, тендер ирүүлэх боломжтой байх шаардлагатай боловч худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулж буй тендер шалгаруулалтад гадаадын этгээд тоон гарын үсэг эзэмшдэггүй гэдэг шалтгаанаар оролцоход хүндрэлтэй байдал үүсдэг. Энэ шалтгаанаар Засгийн газраас хэрэгжүүлж буй цахим шилжилтийн хүрээнд худалдан авах ажиллагааг 100 хувь цахим системд шилжүүлж, ил тод байдлыг хангах нөхцөл	3.Саналыг тусгасан.
--	--	----------------------------

		буурдаг бөгөөд гадаадын иргэн, хуулийн этгээдийг оролцуулах шаардлагатай гэдэг үндэслэлээр худалдан авах ажиллагаанд тендерийг “уламжлалт” хэлбэрээр буюу цаасаар хүлээн авах тохиолдол байдаг. Иймд энэхүү хүндрэлийг үүсгэхгүйн тулд зөвхөн оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэнд гэрчилгээ олгоно гэсэн зохицуулалтыг хасах, мөн гадаадын иргэн, хуулийн этгээд цахим системээр дамжуулан нэг удаагийн эсвэл харьцангуй богино хугацаанд хүчинтэй цахим гарын үсэг эзэмших хүсэлтээ энгийн, хялбар аргаар (онлайнаар) гаргаж болдог зохицуулалтыг бий болгох, түүнийг үнэн зөвийг тусгай зөвшөөрөл бүхий этгээд бүрэн хариуцахаар зохицуулах; 4.Хуулийн төслийн 27 дугаар зүйлийн 27.3.2 дахь заалтад тусгай зөвшөөрөл олгоход улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримтыг хавсаргана гэсэн байна. Иймд хуулийн төслийг дагалдуулан Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн төслийг боловсруулах; 5.Хуулийн төслийн 31 дүгээр зүйлд Монголын үндэсний гэрчилгээжүүлэх байгууллагыг шинээр байгуулахаар заасан байна. Энэ нь Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуультай болон дунд хугацаанд шинээр бүтэц, орон тоо, урсгал зардлыг нэмэгдүүлэхгүй байх Засгийн газрын зарчимтай зөрчилдөж байна. Түүнчлэн, Хууль тогтоомжийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт хууль тогтоомжийн төслийг үзэл баримтлалд нь нийцүүлэн боловсруулна гэж заасан. Мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэгт хууль санаачлагч хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсны, эсхүл хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр хуулийн төсөл, үзэл баримтлалын төсөл боловсруулна гэж, 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтад төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоог хийх, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.4 дэх заалтад Улсын Их Хурлын аливаа шийдвэр нь төсөвт үзүүлэх нөлөөллийн талаарх дүгнэлтэд үндэслэсэн байна гэж тус тус заасан боловч эдгээр баримт бичгийг ирүүлээгүй байна.	4.Саналыг тусгасан. 5.Саналыг тусгасан.
3.	Гадаад харилцааны сайд 2021.04.02-09/1461	Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дараах саналыг хүргүүлж байна. Үүнд: 1.Хуулийн этгээд цахим хэлбэрээр мэдээлэл дамжуулахдаа тоон гарын үсэг болон цахим	1.Хуулийн төслөөр хамтад нь

		тамгыг хамтад нь хэрэглэж болох эсэх талаар хуулийн төсөлд зохицуулалт хийх; 2.Хуулийн төслийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэгт тусгасан “хэрэв 5 жилээс дээш хугацаагаар оршин суух бол гэрчилгээг 5 жилийн хугацаагаар олгоно.” гэсэн өгүүлбэрийг хасаж, найруулгын алдааг засах зэрэг болно.	хэрэглэхгүй байхаар тусгасан. 2.Томьёоллыг өөрчилж тусгасан.
4.	Батлан хамгаалахын сайд 2021.03.26-1a/973	Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй танилцаад дэмжиж, цахим гарын үсгийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах чиглэлээр хуулийн төслийн 33 дугаар зүйлийн 33.1.5 дахь хэсгийн “...хадгалах...” гэсний дараа “цахим гарын үсгийг хуурамчаар үйлдэх, өөрчлөхөөс хамгаалах” гэж нэмэх саналтай байна.	Цахим гарын үсгийг хуурамчаар үйлдэхээс хамгаалах журам хийх боломжгүй бөгөөд хуурамчаар үйлдсэн тохиолдолд холбогдох хуулиар хариуцлага хүлээнэ.
5.	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд 2021.03.24-01/1306	Таны ирүүлсэн Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох материалтай танилцлаа. Хуулийн төслийг дэмжиж байна.	Дэмжсэн санал ирүүлсэн.
6.	Эрүүл мэндийн яам 2021.03.25-1a/1304	Танай 2021 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн албан бичгээр ирүүлсэн Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй танилцлаа. 1.Төслийн 3.1-т "... төрийн нууцад хамааруулснаас ..." гэснийг Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 5.1.1-т, 5.1.2-т нийцүүлэн “... төрийн болон албаны нууцад хамааруулснаас...” гэж; 2.Төслийн 2.1-т"... Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Нийтийн мэдээллийн тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, энэ хууль болон эдгээр хуультай ..." гэснийг “... Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, энэ хууль болон эдгээр хуультай ..." гэж өөрчлөх саналтай байна.	1.Зохицуулалтыг хэвээр үлдээсэн. 2.Зохицуулалтыг хэвээр үлдээсэн.
7.	Боловсрол, шинжлэх ухааны сайд 2021.04.05-1a/1684	Таны санал авахаар ирүүлсэн Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй танилцан дараах саналтай байна. Үүнд: 1.Хуулийн төслийн 8.4-8.6 дахь хэсгийн сонголт 2 гэснийг дэмжиж байна. 2.Хуулийн төслийн 15.2.2, 16.2-т “...хэрэв байхгүй бол” гэснийг “эсхүл” гэж, мөн төслийн 16.5-д “...тогтооно.” гэснийг “батална.” гэж, мөн төслийн 17.1.1, 18.1.3-т “...өөр” гэснийг “бусад” гэж, мөн төслийн 23.2-т “...компани” гэснийг “хуулийн этгээд” гэж тус тус өөрчлөх. 3.Хуулийн төслийн 32.1.4-т “нийтийн түлхүүрийн дэд бүтцийн стандартыг батлах” гэсэн нь Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай /шинэчилсэн	1.Саналыг тусгасан. 2.Зарим саналыг тусгасан. 3.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний

		найруулга/ хуулийн 9 дүгээр зүйлтэй нийцэхгүй байх тул тус хуультай нийцүүлэх. 4.Хуулийн төслийн 20.1-д заасан “Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хуульд” гэснийг зөв нэршлээр нь нэрлэн заах.	итгэмжлэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасан тул зохицуулалтыг хэвээр үлдээсэн. 4.Уг хуулийн нэрийг хуулийн төслөөс хассан болно.
8.	Зам, тээврийн хөгжлийн яам 2021.03.26-01/1255	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 1/1255 тоот албан бичгээр ирүүлсэн Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дараах саналыг өгч байна. Үүнд: 1.Хуулийн төслийн нэр Цахим гарын үсгийн тухай хууль гэсэн боловч зөвхөн төслийн 5 дугаар зүйлд “цахим гарын үсэг хэрэглэх” гэж тусгаж, хуулийн бусад заалт бүхэлдээ тоон гарын үсгийн талаарх агуулгыг илэрхийлсэн байгааг анхаарах; 2.Хуулийн төсөлд цахим гарын үсэг болон тоон гарын үсгийг ямар тохиолдолд хэрэглэх талаар ялгаа заагийг тодорхой тусгах зэрэг болно.	1.Гадаад улс орнуудын жишгийг баримтлан хуулийн төслийг боловсруулсан болно. 2.Хуулийн төсөлд зохицуулалтын ялгааг тусгасан болно.
9.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам 2021.03.25-1/1954	Танай 2021 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 1/1258 дугаартай албан бичгээр ирүүлсэн Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох материалтай танилцлаа. Хуулийн төсөлд тусгайлан өгөх саналгүй байна.	Тусгайлан саналгүй болно.
10.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд 2021.04.01-1/881	Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй танилцлаа. 1.Хуулийн төслийн 4 дүгээр зүйлд “цахим тамга” нэр томъёоны тодорхойлолт нэмэх; 2.Хуулийн төсөлд гарын үсгийн гэрчилгээ эзэмшигч төрийн байгууллага цахим гарын үсгийн бүртгэл хариуцсан ажилтантай байх эсэх талаар тодорхой тусгах зэрэг болно.	1.Нэр томъёоны тодорхойлолт хийх шаардлагагүй. 2.Саналыг тусгах шаардлагагүй.
11.	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд 2021.03.25-01/715	Танаас ирүүлсэн Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, үзэл баримтлал, танилцуулгатай танилцаад дараах саналыг хүргүүлж байна. 1.Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.4, 8.5 дахь хэсгүүдийг тус тус 2 хувилбартайгаар боловсруулсан нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29.1.5-д заасантай нийцэхгүй байна. Тус яамны зүгээс дээрх төслөөс 8.4, 8.5 дахь хэсгийн "сонголт 2"- т заасан хувилбарыг дэмжиж байна; 2.Хуулийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага, түүнтэй холбоотой бусад хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг ирүүлээгүй тул уг асуудлаар санал өгөх боломжгүй байх бөгөөд энэ нь Хууль	1.Саналыг тусгасан. 2.Саналыг тусгасан.

		тогтоомжийн тухай хуулийн 29.1.5, 29.19, 29.1.10- д заасантай нийцэхгүй байгааг анхаарах.	
12.	Эрчим хүчний сайд 2021.03.30-а/1091	Танаас ирүүлсэн Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй танилцаад дараах саналыг хүргүүлж байна: 1.Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг сонголт 2-оор хуульчилж, тус заалтын “иргэн” гэсний дараа “нь” гэж нэмэх; 2.Хуулийн төслийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийг “Улсын бүртгэлийн байгууллагаас Монгол Улсын иргэнд олгох тоон гарын үсгийг иргэний үнэмлэхийн санах ойд үнэ төлбөргүй байршуулна” гэж өөрчлөн найруулах саналтай байна.	1.Саналыг тусгах шаардлагагүй. 2.Төслийн 12.2-т энэ талаар тусгасан байгаа тул давхардуулан тусгах шаардлагагүй.
13.	Соёлын сайд 2021.03.26-1/731	Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй танилцаад дараах саналтай байна: 1.Хуулийн төслийн 6.4-т “төрийн албан хаагч энэ хуулийн 6.1-д зааснаас гадна төрийн албан тушаалыг эрхэлж эрх, үүргээ хэрэгжүүлэхдээ тоон гарын үсэг хэрэглэж болно” гэж заасантай холбогдуулан хуулийн төслийн 4.1.2, 4.1.3, 4.1.4, 14.1, 15.1 дэх хэсгийн “иргэн, хуулийн этгээд” гэсний дараа “төрийн албан хаагч” гэж нэмэх; 2.Хуулийн төслийн 8.4 дэх хэсгийг хоёр өөр агуулгаар томъёолж, хоёр хувилбараар оруулсан нь ойлгомжгүй байгаа тул аль нэг оновчтой зохицуулалтыг сонгож төсөлд тусгах; 3.Хуулийн төсөлд “гэрчилгээжүүлэх байгууллага”, “Үндэсний гэрчилгээжүүлэх байгууллага” гэж заасныг ойлгомжтой байдлаар ялгаа заагийг гарган томъёолох; 4.Хуулийн төслийн 11.1 дэх хэсэгт гэрчилгээг төрийн албан хаагчид ямар хугацаагаар олгох тухай нэмж оруулах; 5.Хуулийн төслийн 12.1 дэх хэсэгт “төрийн албан хаагчид тоон гарын үсгийг үнэ төлбөргүй олгоно” гэж нэмэх; 6.Хуулийн төслийн 4.1.10, 20.1 дэх хэсэгт гэрчилгээжүүлэх байгууллага нь Улсын бүртгэлийн байгууллага, тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд байна гэж заасантай уялдуулан Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн холбогдох зүйл, хэсэгт нэмэлт оруулах хуулийн төсөл боловсруулах зэрэг болно.	1.Нэмж тусгах шаардлагагүй. 2.Саналыг тусгасан. 3.Төслөөс “Үндэсний гэрчилгээжүүлэх байгууллага” гэснийг хассан. 4.Холбогдох журмаар зохицуулахаар тусгасан. 5.Саналыг тусгаагүй. 6.Саналыг тусгасан.
14.	Монголбанк 2021.03.12-А-16/256	Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх болон 2011 оны 12 сарын 15-ний өдөр батлагдсан Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийг илүү сайжруулах зорилгоор боловсруулж буй тус	Саналыг тусгах боломжгүй.

		хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дэмжиж буйг илэрхийлье. Монголбанк нь Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтаар “Үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих,” гэж заасан чиг үүргийнхээ дагуу банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулдаг. Өнөөдрийн байдлаар банкны төлбөр тооцооны үйлчилгээ цахим хэлбэрт бүрэн шилжиж байгаа тул мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах нь маш чухал болоод байгаа бөгөөд энэ хүрээнд Монголбанк бодлого үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна. Банкны цахим үйлчилгээний найдвартай байдлыг нэмэгдүүлэх, цахимаар найдвартай нэвтрэх боломж хангагдсанаар банкны үйл ажиллагааны зардал урт хугацаандаа буурах боломжтой юм. Хуулийн төслөөр гэрчилгээ олгох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага олгохдоо компанид олгохоор тусгагдсан байх бөгөөд хуулийн төслийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэгт “Тэрчилгээ олгох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл /цаашид “тусгай зөвшөөрөл” гэх/-ийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа компанид олгож болно.” гэж заасан байна. Энэхүү зохицуулалтаар тоон гарын үсгийн гэрчилгээ олгох тусгай зөвшөөрлийг тус хуулийн 24 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан Монгол улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа компани байхаар тусгажээ. Иймд Монголбанкны Үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих чиг үүргийн дагуу санхүүгийн байгууллагуудад зориулсан тоон гарын үсгийн тусгай зөвшөөрлийг Монголбанкаас олгохтой холбоотой өөрчлөлтийг Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.10, 20 дугаар зүйлийн 20Л, 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэгт оруулах саналтай байна. Цахим гарын үсгийн гэрчилгээ олгох тусгай зөвшөөрлийг Монголбанкинд олгосноор Монгол Улс цахим орон болох шилжилтийг хурдацтай хийхэд чухал хувь нэмэртэй байх болно.	
15.	Тагнуулын ерөнхий газар 2021.04.02-496	Тус газарт 2021 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 1/1258 дугаартай албан бичгээр санал авахаар ируулсан Цахим гарын үсгийн тухай	

	хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дараах саналыг хүргүүлж байна. 1.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийг “3.1.Төрийн болон албаны нууцад хамааруулснаас бусад мэдээллийг цахим орчинд иргэн, хуулийн этгээд хооронд дамжуулахтай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна” гэж өөрчлөн найруулах; Тайлбар: Төслийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт төрийн албан хаагч тоон гарын үсэг хэрэглэж болохоор заасан ба чиг үүргээ хэрэгжүүлэхдээ тоон гарын үсэг хэрэглэж, албаны нууцад хамаарах мэдээллийг цахимаар дамжуулж болохоор байгаа мэт байна. Гэтэл Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т “албаны нууц” гэж задруулах, урэгдүүлэх тохиолдолд салбарын болон төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн ашиг сонирхолд хохирол учруулах төрийн хамгаалалтад байх мэдээллийг ойлгоно гэсэн бөгөөд албаны нууцад хамаарах мэдээлэл “нууц” зэрэглэлд багтдаг. Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллийг нууцлах, ил болгох, танилцах, ашиглах, хадгалах, хамгаалах, хяналт тавих харилцааг холбогдох хууль болон Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам”-аар зохицуулдаг. Журамд нууц баримт бичгийг цахимаар илгээх, цахим хэлбэрээр солилцох, цахим түлхүүр, цахим хэрэгсэл ашиглах нөхцөл, уйл ажиллагааг тусгасан байдаг. Түүнчлэн дээрх журмын 6.14 дэх хэсэгт нууцад хамаарах цахим мэдээлэл болон мэдээллийн сан устах, урэгдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор нөөц хуулбарыг хийх, цахим гарын үсгээр баталгаажуулах ажлыг тухайн байгууллага зохион байгуулахаар заасан. 2.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх заалтыг “4.1.9.”тоон гарын үсгийн хэрэгсэл” гэж хувийн түлхүүр ашиглан тоон гарын үсгийг үүсгэх, нийтийн түлхүүр ашиглан тоон гарын үсгийг шалгах боломжтой техник хэрэгсэл, программ хангамжийг;” гэж өөрчлөн найруулах; Тайлбар: Уг заалт нь 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгтэй агуулгын хувьд зөрчилдөж байна. Учир нь төслийн 8.2 дахь хэсэгт “тоон гарын үсгийн хэрэгсэлд тоон гарын үсгийн гэрчилгээ, хувийн түлхүүрийг байршуулна” гэж заасан ба иргэн, хуулийн этгээдийн эзэмших тоон гарын үсгийн хэрэгсэл нь зөвхөн тоон гарын үсэг үүсгэх (зурах), шалгах боломжтой байна. Харин тоон гарын үсгийн	1.Зохицуулалтыг хэвээр үлдээсэн. 2.Саналыг тусгасан.
--	---	--

	нийтийн болон хувийн түлхүүрийг үүсгэх эрх нь зөвхөн гэрчилгээжуулэх байгууллагад байна. 3.Төслийн 4 дүгээр зүйлд “4.1.12.“тоон гарын хэсгийн удирдлагын техник” гэж гэрчилгээжүүлэх байгууллагын эзэмшилд байх тоон гарын үсгийн нийтийн болон хувийн түлхүүрийг үүсгэх, баталгаажуулах боломжтой техник хэрэгсэл, программ хангамжийг” гэж нэмэх; 4.Төслийн 4 дүгээр зүйлд “цахим тамга” гэх нэр томьёог шинээр тодорхойлох; 5.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийг “6.1.Тоон гарын үсгийн гэрчилгээтэй хувийн түлхүүр эзэмшигч иргэн тоон гарын үсэг хэрэглэнэ” гэж, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийг 6.1.Тоон гарын үсгийн гэрчилгээтэй хувийн түлхүүр эзэмшигч хуулийн этгээд цахим тамгыг хэрэглэнэ” гэж тус тус өөрчлөн найруулах; Тайлбар: Тоон гарын үсгийн гэрчилгээнд хувийн түлхүүр агуулагддаггүй бөгөөд тус хуулийн 10.3-т заасан мэдээлэл тусгагдсан байдаг тул “заасан” гэдэг үг тохиромжгүй байна. 6.Төслийн 8.1.2 дахь заалтыг хасч, 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэгт “20.3.4.хувийн түлхүүр болон нийтийн түлхүүрийг үүсгэх, дамжуулахдаа түүний давтагдашгүй байдал болон нууцлалыг хангасан тоон гарын үсгийн удирдлагын техник ашиглах” гэж нэмэх; Тайлбар:Хувийн болон нийтийн түлхүүрийг үүсгэх, дамжуулахад давтагдашгүй байдал, нууцлалыг хангахыг гэрчилгээжүүлэх байгууллагад үүрэг болгох нь оновчтой. 7.Төслийн 10 дугаар зүйлийн 10.3.2 дахь заалтад иргэн, аж ахуйн нэгжийн регистрийн дугаарыг нэмж тусгах; 8.Төслийн 11 дүгээр зүйлд гэрчилгээ олгогдсон байгууллага, аж ахуйн нэгж татан буугдсан тохиолдолд тоон гарын үсгийн гэрчилгээг даруй хучингүй болгох зохицуулалтыг нэмж оруулах; 9.Төслийн 18 дугаар зүйлийн 18.1.3 дахь заалтад “яаралтай үед өөр” гэснийг “бусад” болгон өөрчлөх, Тайлбар: Гэрчилгээг түдгэлзүүлэх хүсэлт гаргагч нь “яаралтай үе” гэх нөхцөл байдлыг өөрийн үзэмжээр үнэлж хүсэлт гаргаж болох хэдий ч гэрчилгээжүүлэх эрх бүхий байгууллагын зүгээс гэрчилгээг хүчингүй болгох үндэслэлийн нэг нь “яаралтай үе” гэж	3.Саналыг тусгах шаардлагагүй. 4.Нэр томьёоны тайлбар хийх шаардлагагүй. Төслийн 7 дугаар зүйлд зохицуулсан байна. 5.Саналыг тусгаж, томьёоллыг өөрчилсөн. 6.Зохицуулалтыг хэвээр үлдээсэн. 7.Саналыг тусгасан. 8.Төслийн 18.1.4-т заасан байгаа. 9.Саналыг анхаарч, томьёоллыг өөрчилсөн.
--	--	---

		байгаа нь учир дутагдалтай байна. 10.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.3.1 дэх заалтыг “хувийн түлхүүрийг ашиглах нууц үгийг бусдад шилжүүлэхгүй байх” гэж өөрчлөн найруулах. Тайлбар: Эзэмшигчийн тоон гарын үсгийн хэрэгсэлд агуулагдах хувийн түлхүүрийг (түлхүүрийн өгөдлийг) эзэмшигч өөрөө мэдэхгүй, программ хангамжийн түвшинд ашиглагдах олон тооны /криптограф хувиргалтаас хамаарч 77 ба түүнээс дээш тооны/ тэмдэгт байх бөгөөд түүнийг эзэмшигч хэрэглэхдээ зөвхөн ашиглах нууц үгийг мэдэж байх тул тоон гарын үсгийн хэрэгсэлд нэвтрэх нууц үгийг хамгаалах, нууцлах, аюулгүй байдлыг хангах үүргийг эзэмшигч хүлээх шаардлагатай. 11.Төслийн 22 дугаар зүйлийн 22.1.2 дахь заалтад “гэрчилгээ олгох журам” гэснийг “гэрчилгээжүүлэх үйл ажиллагааны журам” гэж өөрчлөх; 12.Төслийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэгт “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь давагдашгүй хүчин зүйл, хүндэтгэн үзэх шалтгааны улмаас зөвшөөрлийн хугацаагаа сунгуулах хүсэлт гаргаагүй тохиолдолд түүнийг нотлох баримтыг үндэслэн үргэлжлүүлэн сунгах эсэхийг харгалзан үзнэ” гэж нэмэх зэрэг болно.	10.Төслийн 14.3.2-т заасан байгаа. 11.Зохицуулалтыг хэвээр үлдээсэн. 12.Саналыг тусгах шаардлагагүй.
16.	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар 2021.03.29-01/299	1.Энэ хуулийн зорилт нь цахим орчинд иргэн, хуулийн этгээд цахим гарын үсэг хэрэглэх, таних, нийтийн түлхүүрийн дэд бүтцийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтооход оршино гэж өөрчлөх; 2.Төслийн 3.1-ийг Төрийн нууцад хамаарахаас бусад мэдээ, баримт бичгийг цахим орчинд илгээх, хүлээн авах, тоон гарын үсгийн гэрчилгээ ашиглан таних, баталгаажуулахтай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна гэж өөрчлөх; 3.Төслийн 4.1.1-д “цахим гарын үсэг” гэж цахим хэлбэрийн мэдээлэл, баримт бичигт гарын үсэг зурсан этгээдийг таних зорилго бүхий хавсаргасан, эсхүл нэгтгэсэн цахим өгөгдлийг гэж өөрчлөх; 4.Төслийн 4.1.3-т “тоон гарын үсгийн гэрчилгээ” гэж иргэн, хуулийн этгээдэд гэрчилгээжүүлэх байгууллагаас тоон гарын үсэг эзэмших эрхийг олгосон, хувийн түлхүүр, холбогдох бусад мэдээллийг агуулсан цахим баримт бичгийг гэж өөрчлөх; 5.Төслийн 4.1.5-д “криптограф” гэж мэдээллийг шифрлэх, тайлах аргачлалыг судалдаг математикийн салбар шинжлэх ухааныг гэж өөрчлөх; 6.төслийн 4.1.15-д “гэрчилгээжүүлэх	1.Саналыг тусгасан. 2.Зарим саналыг тусгасан. 3.Саналыг тусгасан. 4.Томьёоллыг бүхэлд нь өөрчилсөн. 5.Нэр томьёоны тодорхойлолтоос хассан. 6.Саналыг тусгасан.

	бодлого” гэж гэрчилгээний нэр төрөл, зохион байгуулалт, гэрчилгээ олгох байгууллагын хүлээх үүрэг, хариуцлага, төлбөр, хураамж, нууцлал, аудит, бүртгэлийн талаар баримтлах үндсэн чиглэлийг тодорхойлсон баримт бичгийг гэж өөрчлөх; 7.Төслийн 5.1-д Монгол Улсад цахим гарын үсэг, тоон гарын үсэг гэсэн 2 төрлийг мөрдөнө. Цахим гарын үсэг нь иргэн, хуулийн этгээдийг таних зорилгоор үүсгэсэн цахим мэдээлэл, эсвэл гарын үсгийн цахим хуулбар, дүрс, дахин давтагдахгүй дугаар, тэмдэгт байж болно. Тоон гарын үсэг нь танилт, баталгаажуулалтын аюулгүй байдлын шаардлагын үүднээс гэрчилгээжүүлэх байгууллагаас олгосон тоон гарын үсгийн гэрчилгээ, нийтийн түлхүүрийн дэд бүтцийн тусламжтай хөндлөнгийн этгээдээс таних, баталгаажуулах үйл ажиллагааны хэсэг байна гэсэн агуулгаар өөрчлөлт оруулах; 8.Төслийн 6.5-д Хуулийн этгээд тоон гарын үсэг хэрэглэж болох бөгөөд хуулийн этгээдийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдийн хэрэглэх тоон гарын үсэг нь цахим тамга байна. 8.Төслийн 7.5-д Хуулийн этгээд цахим тамгагүй бол 6.1-д заасны дагуу эрх бүхий байгууллагаас олгосон тоон гарын үсгийг хэрэглэнэ. 8.1.2.хувийн түлхүүр үүсгэх, нийтийн түлхүүрийг дамжуулахдаа түүний давтагдахгүй байдал болон нууцлалыг хангасан байх гэж өөрчлөх. 9.Төслийн 8.4-т Иргэний үнэмлэхэд тоон гарын гэрчилгээ суулгах бол энэ хуульд заасан журмын дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчээс олгосон тоон гарын үсгийг Улсын бүртгэлийн байгууллага иргэний үнэмлэхийн санах ойд суулган холбогдох мэдээллийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид хүргүүлнэ гэж өөрчлөх; 10.Төслийн 10.3.1-ийг гэрчилгээ олгосон гэрчилгээжүүлэх байгууллагын нэр, 10.3.2-ыг гэрчилгээ эзэмшигч иргэн бол иргэний эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, регистр, бүртгэлийн дугаар, хуулийн этгээд бол хуулийн этгээдийн оноосон нэр, цахим хаяг, 10.3.6.-г нийтийн түлхүүрийг баталгаажуулсан криптограф хувиргалтын нэрс, 10.3.7-г бусад гэж өөрчлөх; 11.Төслийн 10.5-г хасах; 12.Төслийн 11.1-ийг Гэрчилгээг хувь хүн болон хуулийн этгээдэд 3 жилийн хугацаагаар олгоно гэж өөрчлөх; 13.Төслийн 13.1-ийг Гэрчилгээжүүлэх байгууллага гэрчилгээ олгосон, түүнийг түдгэлзүүлсэн, түдгэлзүүлснийг сэргээсэн,	7.Зохицуулалтыг хэвээр үлдээсэн. 8.Зохицуулалтыг хэвээр үлдээсэн. 9.Найруулгыг өөрчилсөн. 10.Саналыг тусгасан. 11.Саналыг тусгасан. 12.Зохицуулалтыг хэвээр үлдээсэн. 13.Саналыг тусгасан.
--	--	---

		хүчингүй болгосон болон бусад мэдээллийг агуулсан мэдээллийн сантай байна гэж өөрчлөх; 14.Төслийн 14.3.7-г Гэрчилгээ эзэмшигч нь өөрийн хувийн түлхүүрийг зөвхөн тусгай зөвшөөрөл эзэмшигч буюу тоон гарын үсгийн гэрчилгээ олгогч байгууллагад хэсэгчилсэн эсвэл бүтэн байдлаар хадгалуулж болно гэж өөрчлөх; 15.Төслийн 15.1-ийг Гэрчилгээ эзэмших хүсэлтийг иргэн улсын бүртгэлийн байгууллагад, хуулийн этгээдийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тусгай зөвшөөрөл эзэмшигчид цаасан болон цахим хэлбэрээр бичгээр гаргана гэж өөрчлөх; 16.Төслийн 20.2.2-ыг Иргэн хуулийн этгээдийн хүсэлтээр тоон гарын үсгийн гэрчилгээ үүсгэх гэж өөрчлөх; 17.Төслийн 21.4-ийг Тусгай зөвшөөрөл эзэмшигч гэрээний үндсэн дээр бусад этгээдээр бүртгэлийн нэгжийн үүргийг гүйцэтгүүлж болно гэж өөрчлөх; 18.Төслийн 21.2.6-г хүсэлт гаргагчийн мэдээллийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид дамжуулахдаа хувийн түлхүүрийг хуулбарлаж авахгүй байх гэж өөрчлөх; 19.Төслийн 22.1.2-ыг гэрчилгээжүүлэх бодлого, гэрчилгээ олгох журам болгож өөрчлөх; 20.Төслийн 24.1.1-ийг өөрийн гэрчилгээжүүлэх бодлого, гэрчилгээжүүлэх үйл ажиллагааны журмыг олон улсын стандартын дагуу боловсруулж, баталсан байх гэж өөрчлөх; 21.Төслийн 25.1.3-ыг гэрчилгээжүүлэх бодлого, гэрчилгээжүүлэх үйл ажиллагааны журам гэж өөрчлөх; 22.Төслийн 27.2-ыг Тусгай зөвшөөрөл эзэмшигч тусгай зөвшөөрлийн хугацаа дүүсахаас гурван сарын өмнө хугацааг сунгуулах тухай хүсэлтийг харилцаа холбоо, мэдээллийн технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад гаргана гэж өөрчлөх; 23.Төсөлд Харилцаа холбоо, мэдээллийн технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас энэ хуульд заасан журмын дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчээс олгосон тоон гарын үсгийг бусад програмд ашиглах нөхцлийг бүрдүүлсэн програм хангамж нэвтрүүлэх гэж нэмэх.	14.Саналыг тусгасан. 15.Саналыг тусгасан. 16.Саналыг тусгасан. 17.Томьёоллыг өөрчилж, найруулга хийсэн. 18.Саналыг тусгасан. 19.Саналыг тусгасан. 20.Саналыг тусгасан. 21.Саналыг тусгасан. 22.Саналыг тусгасан. 23.Саналыг тусгасан.
17.	Нийгмийн даатгалын ерөнхий газар 2021.03.24- 1/481	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 1/1258 дугаар албан бичгээр ирүүлсэн Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд оруулах саналыг хавсралтаар	

	хүргүүлж байна. 1.Төслийн 4.1.2-ыг Цахим хэлбэрийн мэдээллийн тодорхойлолт гэж нэмэх; 2.Төслийн 4.1.3-т Цахим тамгын тодорхойлолтын талаар тус тус нэмж оруулах; 3.Төслийн 6.5-д Хуулийн этгээд цахим тамга хэрэглэхдээ давхар эрх бүхий албан тушаалтны тоон гарын үсгийг хэрэглэх эсэхийг тодорхой тусгах; 4.Төслийн 10.3-т “Иргэн бол тухайн иргэний давтагдашгүй дугаар буюу регистрийн дугаар /РД/, хуулийн этгээд бол Улсын бүртгэлийн ерөнхий газраас олгож буй хуулийн этгээдийн регистрийн дугаар”, Гадаадын иргэн бол Гадаадын иргэн, харьяатын газраас олгосон дахин давтагдашгүй дугаарыг гэж оруулах. (Цахим орчинд тухайн иргэн, хуулийн этгээдийг танихад энэхүү мэдээллийг ашиглах. Ижил нэртэй иргэн, хуулийн этгээд нилээдгүй байдаг) 5.Гэрчилгээг цахим орчинд хэрхэн тулган баталгаажуулах тухай тусгах. Үүнд: - Тоон гарын үсгийн гэрчилгээний хүчинтэй эсэхийг Үндэсний гэрчилгээжүүлэх байгууллагаас нэгдсэн байдлаар тулган шалгах, үндэсний гэрчилгээжүүлэх байгууллага нь энэ боломжийг бүрдүүлэх - Гэрчилгээжүүлэх байгууллагын үүрэгт нэмж тусгах: Тоон гарын үсгийн гэрчилгээ олгож буй байгууллагууд олгосон гэрчилгээний шаардлагатай мэдээллээ Үндэсний гэрчилгээжүүлэх байгууллагууд илгээж байх гэж үүрэгжүүлэх. Архивлах: Үндэсний гэрчилгээжүүлэх байгууллага нь нэгдсэн мэдээллийн санг дор хаяж 70 жилийн хугацаатай архивлах талаар тусгах шаардлагатай байна. Шүүх болон хууль хяналтын байгууллагаар шалгах шаардлага гарахад тухайн үед энэхүү тоон гарын үсгийн гэрчилгээг хэн гэдэг хүн эзэмшиж байсан талаарх мэдээлэл шаардлагатай байдаг. 6.Төслийн 11.1-д Хуулийн этгээдэд 5 жил гэж оруулах;	1.Төслийн 5.1-д цахим хэлбэрийн мэдээллийн талаар тодорхой бичсэн тул нэр томьёоны тайлбар хийх шаардлагагүй. 2.Нэр томьёоны тайлбар хийх шаардлагагүй. Төслийн 7 дугаар зүйлд цахим тамгатай холбоотой зохицуулалтыг тусгасан байгаа. 3.Тоон гарын үсгийг хэрэглэх шаардлагагүй. 4.Саналыг тусгасан. 5.Зохицуулалтыг хэвээр үлдээсэн. 6.Зохицуулалтыг хэвээр үлдээсэн.
--	--	---

		7.Төслийн 16 дугаар зүйлд Төрийн байгууллага, албан тушаалтанд цахим тамга болон тоон гарын үсгийг хэн олгох талаар тусгах; (10.2-т заасны дагуу журмаар зохицуулах эсэхийг тодорхой болгох)	7.Төрийн албан хаагчид тоон гарын үсэг олгохтой холбоотой журмыг харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тогтоохоор заасан.
18.	Улсын бүртгэлийн ерөнхий газар 2021.03.23-1/1951	Танаас ирүүлсэн 2021 оны 1/1258 тоот албан бичигтэй танилцлаа. Цахим гарын үсгийн тухай хуулийн төсөлд дараах саналыг хүргүүлж байна: 1.Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн "хуулийн этгээдийг" гэснийг "хуулийн этгээд түүнийг төлөөлөх эрх бүхий этгээдийг" гэж өөрчлөх; 2.Хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт "хамгаалах тухай" гэсний дараа "хууль," гэж нэмэх; 3.Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.10 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт "Улсын бүртгэлийн байгууллага," гэснийг "Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага," гэж өөрчлөх; 4.Хуулийн төслийн 4 дүгээр зүйлд дараах агуулга бүхий 4.1.11 дэх заалт нэмж, "4.1.11" дэх заалтыг "4.1.12" гэж өөрчлөх: "4.1.11."үндэсний гэрчилгээжүүлэх байгууллага" гэж гэрчилгээжүүлэх байгууллагын нийтийн түлхүүрийг гэрчилгээжүүлж, гэрчилгээ олгосон, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тухай мэдээллийг агуулсан Гэрчилгээний үндэсний нэгдсэн сангийн хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг ханган ажиллах тусгай үүрэг бүхий байгууллагыг."; 5.Хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн "заасан" гэсний дараа "16 насанд хүрсэн" гэж нэмэх; 6.Хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсгийн "хуулийн этгээдийн" гэснийг "хуулийн этгээдийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдийн" гэж өөрчлөх; 7.Хуулийн төслийн 6 дугаар зүйлд дараах агуулга бүхий 6.6 дахь хэсэг нэмэх: "6.6.Хуулийн этгээдийн ажилтан энэ хуулийн 6.1-д зааснаас гадна албан тушаалыг эрхэлж,	1.Төслийн 7.2, 7.3-т хуулийн этгээдийг төлөөлөх этгээдийн талаар нарийвчлан тусгасан тул нэмж тусгах шаардлагагүй. 2.Саналыг тусгасан. 3.Зохицуулалтыг хэвээр үлдээсэн. 4."Үндэсний гэрчилгээжүүлэх байгууллага"-тай холбоотой зохицуулалтыг хассан. 5.Нэмж тусгах шаардлагагүй. Зохицуулалт ойлгомжтой. 6.Төслийн 7.2, 7.3-т хуулийн этгээдийг төлөөлөх этгээдийн талаар нарийвчлан тусгасан тул нэмж тусгах шаардлагагүй. 7.Төслийн 6.4-т Төрийн албан хаагч төрийн албан тушаалыг эрхэлж,

	эрх, үүргээ хэрэгжүүлэхдээ тоон гарын үсэг хэрэглэж болно.”; 8.Хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.5, 8 дугаар зүйлийн 8.3, 8.4 дэх хэсгийг хасах; 9.Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтын “үүсгэх,” гэсний дараа “мөн нийтийн түлхүүрийг” гэж нэмэх; 10.Хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “байгууллагын” гэсний дараа “даргын” гэж нэмэх; 11.Хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 10.3.2 дахь заалтад “иргэн бол” гэсний дараа “иргэний бүртгэлийн дугаар,” гэж нэмэх; 12.Хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 10.4.3 дахь заалтын “бусад.” гэснийг “хуульд заасан бусад.” гэж өөрчлөх; 13.Хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн “иргэнд 5 жил,” гэснийг “иргэнд 4 жил,” гэж, “5 жилийн” гэснийг “4 жилийн” гэж, “гадаадын иргэнд” гэснийг “гадаадын иргэн, харьяалалгүй хүнд” гэж өөрчлөх; 14.Хуулийн төслийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийг дараах байдлаар өөрчлөн найруулах: “12.2.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас иргэнд тоон гарын үсгийг анх удаа олгоход энэ хуулийн 12.1 дэх хэсэг үйлчлэхгүй.” 15.Хуулийн төслийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэгт “хэрэв 5 жилээс дээш хугацаагаар оршин суух бол гэрчилгээг 5 жилийн хугацаагаар олгоно.” гэснийг хасах; 16.Хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.2.1 дэх заалтын “иргэний үнэмлэхийн дугаар хуулийн этгээд бол хуулийн этгээдийн оноосон нэр, улсын бүртгэлийн дугаар,” гэснийг “иргэний бүртгэлийн дугаар, хуулийн этгээд бол хуулийн этгээдийн оноосон нэр,	эрх, үүргээ хэрэгжүүлэхдээ тоон гарын үсэг хэрэглэж болохоор, 16.8-д Төрийн албан хаагчид гэрчилгээ олгох, түүнийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой харилцааг харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын баталсан журмаар зохицуулахаар тусгасан. 8.Зохицуулалтыг хэвээр үлдээсэн. 9.Саналыг авч, томьёоллыг өөрчилсөн. 10.Саналыг тусгасан. 11.Саналыг тусгасан. 12.Төслийн 10.4.3-ыг хассан. 13.Зохицуулалтыг хэвээр үлдээсэн. 14.Зохицуулалтыг хэвээр үлдээсэн. 15.Зохицуулалтыг өөрчилж тусгасан. 16.Саналыг тусгасан.
--	---	--

	хэлбэр, регистрийн дугаар,” гэж өөрчлөх; 17.Хуулийн төслийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийг дараах байдлаар өөрчлөн найруулах; “15.1.Тоон гарын үсгийн гэрчилгээ эзэмших хүсэлтийг дараах байгууллагад гаргана: 15.1.1.иргэн гэрчилгээ эжүүлэх байгууллагад; 15.1.2.төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан Үндэсний гэрчилгээжүүлэх байгууллагад; 15.1.3.хуулийн этгээдийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд, гадаадын иргэн, харьяалалгүй хүн тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдэд.”; 18.Хуулийн төслийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийг хасах; 19.Хуулийн төслийн 15 дугаар зүйлийн 15.2.2 дахь заалтын “регистрийн дугаар, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн дугаар,” гэснийг “иргэний бүртгэлийн дугаар, хуулийн этгээдийн регистрийн дугаар,” гэж өөрчлөх; 20.Хуулийн төслийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “Улсын бүртгэлийн байгууллага иргэн, тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдийн” гэснийг “энэ хуулийн 15.1-д заасны дагуу гаргасан” гэж өөрчлөх; 21.Хуулийн төслийн 17 дугаар зүйлийн нэрийг “Гэрчилгээг түдгэлзүүлэх” гэснийг “Гэрчилгээг түдгэлзүүлэх, сэргээх” гэж өөрчлөх; 22.Хуулийн төслийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсэгт “тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэснийг “гэрчилгээжүүлэх байгууллага” гэж өөрчлөх; 23.Хуулийн төслийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтад “гэрчилгээжүүлэх байгууллагад” гэснийг хасах; 24.Хуулийн төслийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт “нэгжийн” гэснийг “үйл ажиллагааны” гэж өөрчлөх; 25.Хуулийн төслийн 20 дугаар зүйлийн 20.2.13 дахь заалтад “даруй гэрчилгээний мэдээллийн санд оруулах,” гэснийг “Үндэсний гэрчилгээжүүлэх байгууллагын нэгдсэн санд тухай бүр оруулах,” гэж өөрчлөх;	17.Томьёоллыг өөрчлөн найруулсан. 18.Саналыг тусгасан. 19.Саналыг тусгасан. 20.Саналыг тусгасан. 21.Саналыг тусгасан. 22.Саналыг тусгасан. 23.Саналыг тусгасан. 24.Холбогдох хуулийн нэрийг хассан. 25.Зохицуулалтыг хэвээр үлдээсэн.
--	---	--

		26.Хуулийн төслийн 20 дугаар зүйлийн 20.3, 20.4 дэх хэсгийн дугаарлалтыг засах; 27.Хуулийн төслийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэг, 27.7 дахь хэсэгт заасан хугацаа хоорондоо зөрчилдөж байгааг нийцүүлэх; 28.Хуулийн төслийн 8 дугаар бүлэгт үндэсний гэрчилгээжүүлэх байгууллагын чиг үүргийг нэмж тусгах; 29.Хуулийн төслийн 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсэгт “байгууллага батална.” гэснийг “байгууллагын дарга батална.” гэж өөрчлөх; 30.Хуулийн төслийн “Хоёрдугаар бүлэг”-т заасан Цахим болон тоон гарын үсэг хэрэглэхтэй холбоотой зохицуулалтыг утгын хувьд дараалалд оруулж “Дөрөвдүгээр бүлэг”- т заасан Гэрчилгээ олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбоотой зохицуулалтын дараа оруулах саналтай байна.	26.Саналыг тусгасан. 27.Саналыг тусгасан. 28.“Үндэсний гэрчилгээжүүлэх байгууллага”-тай холбоотой зохицуулалтыг хассан. 29.“Үндэсний гэрчилгээжүүлэх байгууллага”-тай холбоотой зохицуулалтыг хассан. 30.Зохицуулалтыг хэвээр үлдээсэн.
19.	Архивын ерөнхий газар 2021.03.25-01/185	Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй танилцаад тус газраас дараах саналтай байна. Үүнд: 1.Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Цахим гарын үсгийн тухай хуулийн дагуу олгогдсон тоон гарын үсэгтэй холбоотой асуудлыг хэрхэн зохицуулах талаар энэ хуульд, эсхүл дагаж мөрдөх журмын тухай хуульд тусгах; 2.Төслийн 6 дугаар зүйлд “6.6.Төрийн байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд тоон гарын үсэг хэрэглэх, ашиглах харилцааг Монгол Улсын Засгийн газраас баталсан “Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам”, “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-аар тус тус зохицуулна” гэж нэмэх; 3.Төслийн 3.3-т “Цахим хэлбэрээр хэлцэл хийхтэй холбогдсон энэ хуулиар зохицуулснаас бусад харилцааг ..” гэж заасан боловч цахим хэлбэрээр хэлцэл хийхтэй холбоотой асуудал энэ хуульд тусгагдаагүй байх тул хасах;	1.Саналыг анхаарч, шилжилтийн үеийн зохицуулалтыг тусгасан. 2.Нийтийн мэдээллийн тухай хуулиар энэ талаар зохицуулсан. 3.Зохицуулалтыг хэвээр үлдээсэн. Энэ хууль нь бүхэлдээ цахим хэлбэрийн мэдээлэлд цахим гарын үсэг ашиглахтай холбоотой харилцааг зохицуулж байгаа тул цахим хэлбэрийн хэлцэл томъёоллоор тусгаагүй ч энэ

		4.Холбогдох хууль тогтоомжид зааснаар тамга, тэмдгийг төрийн байгууллага, тэмдгийг хувийн хэвшлийн хуулийн этгээд хэрэглэдэг тул “цахим тамга” гэсэн нэр томъёог өөрчлөх; 5.төслийн 23.3, 31.2 дахь хэсгийг дахин найруулж, түүнчлэн төслийн 27.2, 27.7 дахь хэсгийг хооронд нь уялдуулах.	талаарх ерөнхий агуулгаар нь зохицуулж байгаа. 4.Олон улсад хэрэглэдэг нэршлээр тусгасан тул зохицуулалтыг хэвээр үлдээсэн. 5.Саналыг тусгасан.
20.	Монголын өмгөөлөгчдийн холбоо 2021.04.06-01/331	Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон дагалдах хуулийн төслүүдийг бүхэлд нь дэмжиж байна.	Дэмжсэн санал ирүүлсэн.

Түүнчлэн энэхүү шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг шалгахдаа Хууль тогтоомжийн тухай хуулийн дараахь заалтад заасан шаардлагыг хангасан эсэхэд хариулт өгөх замаар шалгалаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Шаардлага хангасан.
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Шаардлага хангасан.
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан. Хуулийн төсөлд одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа журмаар зохицуулж байсан зарим суурь харилцааг тусгасан байгаа нь хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх шаардлагад нийцсэн гэж үзэж байна.
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ	Шаардлага хангасан.

тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Шаардлага хангасан.
29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Энэ хуулийн дагаж Зөрчлийн тухай болон Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа болно.
29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Хуулийг дагаж Хууль хүчингүй болсонд тооцох тухай, Иргэний хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай зэрэг хуулийн төслийг боловсруулсан байна.
29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Хуулийн төслийн 1.1-д тус хуулийн зорилтыг тодорхойлсон бөгөөд энэ хуулийн зорилт нь цахим орчинд иргэн, хуулийн этгээд цахим гарын үсэг хэрэглэхтэй холбоотой харилцааг зохицуулах, түүнд тавигдах эрх зүйн болон техникийн шаардлагыг тогтоох замаар иргэн, хуулийн этгээдийг таних, баталгаажуулахаар тусгасан.
Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Шаардлага хангасан.
30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Шаардлага хангасан.
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Шаардлага хангасан.
30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Шаардлага хангасан.
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Шаардлага хангасан.

“Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлалд заасан дараахь асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог бүхэлд нь шалгахыг зорьлоо.

д/д	Асуулт	Хариулт буюу дүн шинжилгээ
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Шаардлага хангасан.
2	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;	Хуулийн төслийн 2.1-д Цахим гарын үсгийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль ² , Иргэний хууль ³ , Нийтийн мэдээллийн тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх;	Хуулийн төсөлд хэрэглэсэн нэр томьёог тодорхойлж, тайлбар хийсэн байх бөгөөд энэ нь хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байна гэж үзсэн.
4	хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Шаардлага хангасан.
5	хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Хууль хооронд болон хуулийн төсөлд давхардсан зохицуулалт байхгүй гэж үзлээ.
6	хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	Хуулийн төслийн 20, 31, 32, 33 дугаар зүйлд энэ хуулийг хэрэгжүүлэх этгээдийг заасан.
7	хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Цахим гарын үсгийг хэрэглэхэд хамаарах шаардлагатай бүх суурь харилцаануудыг зохицуулахыг зорьсон байна.
8	хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Давхардуулан тусгаагүй гэж үзсэн.
9	төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Тоон гарын үсгийн гэрчилгээг төслийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээд олгож болохоор тусгасан. Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэхэд хязгаарлалт тогтоогоогүй.
10	татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	2011 онд Цахим гарын үсгийн тухай хуулийг батлахдаа Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд дагаж нэмэлт оруулаагүй байсан алдааг засаж, тус хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан байна.
11	тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй холбоотой харилцааг одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Ажлын ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай

² Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

³ Иргэний хууль, Төрийн мэдээлэл эмхтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

		хуулиар зохицуулж байгаа тул уг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаарлагагүй.
12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулаагүй.
13	хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Хуулийн төсөл нь жендэрийн эрх тэгш байдлын асуудлыг хөндөөгүй.
14	хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Хуулийн төсөл нь шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн зохицуулалт тусгагдаагүй.
15	хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Хуулийн төсөл нь авлига, хүнд бий болгоход чиглэсэн зохицуулалт тусгагдаагүй.
16	хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн хуулийн тоон гарын үсгийг хэрэглэхтэй холбоотой зохицуулалтад өөрчлөлт оруулсан.

ТАВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

5.1.Баримтжуулалт

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхэд ашигласан дараахь баримт бичиг, мэдээлэл, тоо баримтыг цуглуулан үр нөлөөг тооцох ажиллагааны тайланд баримтжуулж хавсаргалаа.

1. Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан;
2. Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, түүнд нийцүүлж боловсруулсан хуулийн төслийн хувилбар;
3. Хуулийн төсөлд төрийн болон төрийн бус нийт ... байгууллагаас ирүүлсэн санал.
4. Хууль тогтоомжийн тухай хууль 2015 он;
5. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”;

5.2. Үнэлэлт дүгнэлт

Энэхүү үнэлгээний ажлын явцад төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөлтэй уулзаж ярилцах, хэлэлцүүлэг зохион байгуулах, албан бичгээр санал авах, дотоодын болон гадаадын улс орны сайн туршлага бүхий хуультай харьцуулах, давхардал хийдлийг илрүүлэхээр хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжид харьцуулсан дүн шинжилгээ хийх зэрэг аргыг хэрэглэхээс гадна энэ асуудлын хүрээнд хийгдсэн албан ёсны судалгааг ашигласан болно.

Хуулийн төслийн үр нөлөөг шалгуур үзүүлэлт бүрээр дараах байдлаар үнэлж дүгнэлээ.

Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтээр:

Хуулийн төслийн зорилго, зорилт нь хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлага, үндэслэлүүдтэй нийцэж байгаа болон үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг бүрэн илэрхийлж чадсан эсэхэд, мөн хуулийн төслийн зорилгыг уг хуулийн бусад зохицуулалтууд хангаж, илэрхийлж чадахаар бүрэн гүйцэд томъёологдсон эсэхэд үнэлгээ хийхэд хуулийн төслийн 1 дүгээр зүйлээр тодорхойлсон зорилт нь үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлага, үндэслэлийг хангалттай хэмжээнд илэрхийлж чадсан байна.

Түүнчлэн Цахим гарын үсгийн тухай хуулийг шинэчилсэн найруулгаар боловсруулах шаардлагатай эсэхийг Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын хүрээнд холбогдох судалгааг хийж үзэл баримтлалд хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагыг бүрэн дүүрэн, ойлгомжтой байдлаар тодорхойлсон гэж дүгнэв.

Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төсөлд тодорхойлсон зорилтыг бүрэн илэрхийлж, үүнийг хэрэгжүүлэхэд чиглэгдэж чадсан эсэхийг үнэлэхээр хуулийн төслийн 3.1, 4.1, 5.1 дэх хэсэг, 6, 7, 8, 11, 12 дугаар зүйлийг сонгон авч тухайн асуудалд хамааралтай хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжид тулгуурлан үнэлгээг хийлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт зөвхөн төрийн нууцтай холбоотой мэдээлэл дамжуулахад цахим гарын үсэг хэрэглэхгүй байхаар зааж, албаны болон байгууллагын нууцтай холбоотой мэдээлэл дамжуулахад хязгаар тогтоолгүйгээр цахим гарын үсэг хэрэглэж болохоор хуулийн үйлчлэх хүрээг өргөжүүлэн тогтоосон нь хуулийн төслийн үзэл баримтлалд заасан цахим гарын үсэг, тэр дундаа тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн хувьд хуулийн төслийн зорилтыг хангаж, агуулгын хувьд өргөн утгатай, практикт хэрхэн ойлгох нь тодорхойгүй, хууль хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэх, хууль эрх зүйн маргаан дагуулж болзошгүй хуулийн төсөлд хэрэглэсэн зарим нэр томъёог тайлбарласан нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4 дэх хэсэгт заасан шаардлагад нийцсэн байна. Тухайлбал; хуулийн төсөлд хэрэглэсэн “цахим гарын үсэг”, “тоон гарын үсэг”, “тоон гарын үсгийн гэрчилгээ, түүнийг эзэмшигч”, “цахим баримт бичиг”, “тоон гарын үсгийн хэрэгсэл”, “тоон гарын үсгийн нийтийн болон хувийн түлхүүр” зэрэг ойлголтууд нь агуулгын хувьд өргөн утгатай, практикт хэрхэн ойлгох нь тодорхойгүй, хууль хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэх, хууль эрх зүйн маргаан дагуулж болзошгүйг харгалзан нэр томъёоны тайлбар хийжээ.

Хуулийн төслийн 5, 6, 7, 8 дугаар зүйлийн хувьд цахим гарын үсгийг хэрэглэх тохиолдлыг илүү өргөн хүрээнд тодорхойлж, иргэн, хуулийн этгээдийн хэрэглэх цахим гарын үсгийн тоо, хэлбэрт хязгаар тогтоохгүй байх суурь зарчмыг хадгалж, цахим гарын үсгийн нэг төрөл болох тоон гарын үсэгт тавигдах шаардлагыг тогтоож, гадаад улс орнуудын жишгийн дагуу тоон гарын үсэг нь цаасан хэлбэрт байгаа мэдээлэлд зурсан гарын үсэгтэй адил хүчинтэй байх, хуулийн этгээд цахим тамга хэрэглэж болохоор, тоон гарын үсгийн хэрэгслийн төрөлд хязгаар тогтоохгүй байхаар, иргэний үнэмлэхийг тоон гарын үсгийн хэрэгслээр ашиглах болохоор тусгасан зэрэг нь үзэл баримтлалаар тодорхойлсон иргэн бүр өөрийн хүссэн тоон гарын үсгийн хэрэгсэлд тоон гарын үсгийн гэрчилгээ, хувийн түлхүүрийг байршуулах, хуулийн этгээдэд тоон гарын үсэг хэрэглэж болох сонголтыг олгож, иргэний хэрэглэх тоон гарын үсгээс нэршлийн хувьд ялгаатай хэдий ч тавигдах шаардлага, аюулгүй байдлын хангах нөхцөлийн хувьд ижил тоон

гарын үсгийг цахим тамга хэлбэрээр хэрэглэх үндсийг олон улсын жишигт нийцүүлэн тогтоосон байна.

Хуулийн төслийн 11, 12 дугаар зүйлд тоон гарын үсгийн гэрчилгээний хүчинтэй байх хугацааг уртасган иргэн, хуулийн этгээдэд ялгамжтайгаар олгох, гадаадын иргэн тоон гарын үсэг эзэмших тохиолдолд оршин суух хугацаанаас шалтгаалан хугацаа нь өөр өөр байх зэрэг зохицуулалтыг оруулж, улсын бүртгэлийн байгууллага болон тусгай зөвшөөрөл эзэмшигчээс олгох тоон гарын үсгийн гэрчилгээний үнэ ялгаатай байхаар тусгаж, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тогтоох үнэд төрөөс шууд оролцон, хязгаар тогтоохгүй байхад анхаарч хуулийн төслийг боловсруулсан байна.

Түүнчлэн хуулиас дээгүүр болзол, шаардлагыг дүрэм, журмаар тогтоохоос татгалзаж хуульд нийцсэн байх зарчмын дагуу Харилцаа холбооны зохицуулах хорооны 2014 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 45 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын цахим гарын үсгийн нийтийн түлхүүрийн дэд бүтцийн талаарх журмуудаас хуулиар зохицуулвал зохих суурь зохицуулалтуудыг хуулийн төсөлд тусгасан байна.

Хүлээн зөвшөөрөгдөх байдал шалгуур үзүүлэлтээр:

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд төсөлд тодорхой этгээдүүдэд үүрэг хүлээлгэсэн, аж ахуйн байгууллагын салбарт хүндрэл үүсгэх зохицуулалтыг тусгаагүй тул хүлээн зөвшөөрөгдөх байдал гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгон авах шаардлагагүй гэж үзсэн.

Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтээр:

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхдээ уг хуулийг хэрэгжүүлэх байгууллага болох Улсын бүртгэлийн ерөнхий газраас санал авсан бөгөөд тус байгууллага тоон гарын үсгийн гэрчилгээ олгох байгууллагаар ажиллах боломжтой талаар хариу ирүүлж тухай бүр дэмжиж байгаа талаар саналаа илэрхийлж оролцсон байна. Мөн тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниуд хуулийн этгээдэд тоон гарын үсэг болох цахим тамга олгоход хүндрэл үүсэхгүй талаар саналаа өгчээ.

Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтээр:

Хуулийн төслийн ойлгомжтой байдлыг судлахдаа хуулийн төсөлд төрийн болон төрийн бус байгууллагуудаас санал авч, тэдгээр саналуудаас хуулийн төслийн ойлгомжтой байдал гэсэн шалгах хэрэгслийн хүрээнд өгсөн саналыг агуулгаар нэгтгэн судлахад холбогдох яамд, байгууллагууд зарчмын хувьд дэмжиж холбогдох саналуудаа ирүүлснээс зарим саналыг хуулийн төсөлд тусгажээ.

Түүнчлэн хуулийн төсөл боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хуулийн төсөлд тавигдах нийтлэг шаардлагад нийцсэн байна.

Зардал гэсэн шалгуур үзүүлэлтээр:

Зардал гэсэн шалгуур үзүүлэлтийн дагуу Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын дагуу холбогдох зардлыг тодорхой тооцсон тул энэхүү үнэлгээний тайланд дүгнэлтийг тусгаагүй болно.

Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтээр:

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь үнэлэхийг зорьж, Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан асуултад хариулах байдлаар шалгасан бөгөөд хуулийн төслийг тухайн хуулийн зорилтод нийцүүлж боловсруулсан, хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцсэн, давхардаагүй, хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо нь тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцсэн, хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан, хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулаагүй, хуулийн төсөлд татвар, төлбөр, хураамж тогтоогоогүй, Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалтыг тусгаагүй, шударга өрсөлдөөнийг хязгаарлах, авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн зохицуулалтыг тусгаагүй, одоо үйлчилж байгаа хуулийн бүтэц, зохицуулалтыг илүү ойлгомжтой байдлаар тусгаж, хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгасан зохицуулалтыг тусгасан гэж үзэж байна.

5.3.Зөвлөмж

Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг иргэн, хуулийн этгээд өөрийн хүссэн тоон гарын үсгийн хэрэгслийг сонгон тоон гарын үсгийн гэрчилгээ, хувийн түлхүүрийг байршуулж, өөрийгөө цахим орчинд таньж, баталгаажуулах замаар аливаа этгээдтэй тоон гарын үсгийг хэрэглэн цахим орчинд чөлөөтэй харилцах боломжийг бүрдүүлэх зорилгоор боловсруулсан байна. Хуулийн төслийг “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу үнэлэхэд үзэл баримтлал болон хуулийн төслөөр тавьсан зорилгодоо хүрэх боломжтой, хуулийн төсөл боловсруулах шаардлагад нийцсэн байна.

Харин үр нөлөөг тооцох ажиллагааны явцад гарсан дараахь асуудлуудыг өөрчлөх, дахин анхаарах шаардлагатай байна гэсэн зөвлөмжийг хууль санаачлагчид өгч байна. Үүнд:

1.Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн хүрээнд иргэн, хуулийн этгээдэд олгосон тоон гарын үсгийн гэрчилгээтэй холбоотой асуудлыг хуулийн төслийн зохицуулалтад нийцүүлэх талаар шилжилтийн үеийн зохицуулалтыг бий болгох;

2.Харьяалалгүй хүнд тоон гарын үсэг олгох эсэх асуудлыг шийдвэрлэх;

3.Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулж байгаа зарим харилцааг хуулийн төсөлд эш татахаар заасныг хуулийн төсөлд эш таталгүйгээр бүхэлд нь зохицуулах;

2.Хуулийн төсөлд эшлэл хийсэн хуулийн нэр, хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд нийцүүлэн заах.